



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СТАТИСТИКИЙН ГАЗАР

Нийслэл хот

2010 онд

Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллээр
бэлтгэсэн танилцуулга

2011 он

АГУУЛГА

НСГ-аас 2010 онд хийсэн судалгаа, танилцуулга

- 1 “Нийслэлийн хөгжил, төлөв байдал”
- 2 “Хүн амын амьдарч буй орчин”
- 3 “Хүн амын амьжиргааны түвшин”
- 4 “Ажил эрхлэлтийн байдал”
- 5 “Нийслэлийн хүн ам, өрхийн үзүүлэлт, төлөв байдал”
- 6 “Нийслэлийн мал, тэжээвэр амьтад” судалгааны тайлан
- 7 “Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хийсэн судалгааны тайлан”
- 10 Улаанбаатар хотын нэг өдөр, 2010

Оросын дипломатч, түүхч, академич Иван Михайлович Майскийн “Орчин үеийн Монгол” номонд дүрсэлсэн 1919 оны Автономит Монголын хот хэрхэн өөрчлөгдснийг Та манай нийслэлийн Статистикийн газрын бэлтгэсэн 2008 оны жилийн танилцуулгаас урьд нь мэдэж авсан.

Нийслэлийн Статистикийн газраас сар, улирал, жилийн статистикийн танилцуулга, статистикийн үзүүлэлтээр бэлтгэсэн эмхэтгэл, судалгааг ubstat.mn вэб хуудсаар үнэ төлбөргүй мэдээлж байна.

Энэ удаа нийслэлийн 2010 оны эдийн засаг, нийгмийн статистикийн үзүүлэлтээр бэлтгэсэн танилцуулгад Ж.Гангаагийн “Улаанбаатар бол Монголоос чухал” нийтлэлийг өмнөтгөл болгон орууллаа. Бид статистикийн олон үзүүлэлт, судалгаа шинжилгээний үр дүнг Та бүхэнд албаны, мэргэжлийн үг хэллэгээр танилцуулдаг. Харин энэ нийтлэл нь нийслэл хотын тухай статистикийн мэдээлэл, судалгаа, шинжилгээгээр нотлогдсон бодит байдлыг тун ойлгомжтой, энгийн хэлбэрээр хүүрнэжээ.



Улаанбаатар бол Монголоос чухал

Ж.ГАНГАА

Улаанбаатарт хоёр өдөр "томилолт"-оор ажиллалаа. Хүн биеийнхээ дотор юу болж байгааг мэддэггүйтэй адил тийм мэдрэмж Улаанбаатартай танилцах явцад төрж байв. Эмнэлэгт үзүүлсэн шинжилгээний хариу мэт сайн муу өчнөөн үйл явдал ажил гэр хоёрын хооронд нэгэн хэмээр гэлдрэх зуур болоод өнгөрчээ.

Хэд хоногийн дараа Улаанбаатар байгуулагдсан өдрийг тэмдэглэх юм байна. Өнөө жилийн тэр өдөр нь тийм чухал, тэгш өдөр биш аж. Уг нь Монгол даяараа үүсэн байгуулагдсанахаа 90, 100 жилийн ойгоо нижгэр тэмдэглэж буй түүхт жилсэн. Зөвхөн Их Хүрээ л ганцаараа 372 жилийн өмнө "Ширээ цагаан нуур"-т мэндэлсэн юм даг уу. Ядаж Гандан хийд ч ханьсдаггүй. Сонирхолтой нь нүүдэлчдийн хот олноо дагаад мөн л нүүж явдаг байжээ. 28 удаа буурь сэлгээд 156 жилийн өмнө Сэлбийн хөвөөн дээр төвхнөснөөс хойш дахиж хөдлөөгүй аж. Занабазараас хойших тав дахь Богд: "Одоо энэнээс сайхан газар олдохгүй. Нүүгээд хэрэггүй. Хожим энэ дөрвөн уулын дунд багтахгүй олуулаа амьдарна" хэмээн айлдсан нь архивд хадгалагджээ. V Богдын ерөөл бат оршиж өнөөдөр нүүдэлчид түм буман жилийн түүхэндээ анх удаа сая давсан хүн амтай суурин хоттой болсон юм. Саяхан болтол Улаанбаатарыг Бээжин, Багдад шиг хөл малгай нь төөрөлдсөн нүсэр хот болно гэж Богдоос бусад нь ер төсөөлж байсангүй. Төсөөллөө ч дандаа дутуу тооцоолж, дараа үеийнхэн засахад маш төвөгтэй алдаанууд тунарсан гэж Т.Билэгт дарга хэлж байна. Билэгтийг 1990-ээд оны сүүл үед хот удирдаж байх үед хөдөөнөөс нүүж ирэгсдээс "Яг яах гэж нийслэлд ирж байгаа вэ?" гээд зөвшилцөн нэг нь шилжүүлж нөгөө нь хүлээж авдаг байж. Гэтэл дуртай газраа амьдрах эрхийн тухай Үндсэн хуулийн заалт зөрчлөө гээд шүүхдэлцэн үүнийг болиулжээ. Үүнд тухайн үеийн "Өдрийн сонин" ч багагүй нөлөөлсөн гэлцдэг. Шүүхэд ялагдсан хот хаалгаа нээмэгц хөдөөнийхөн пир хийн ороод ирсэн.

Монгол хүний амьдрахад дурламаар газар бол зөвхөн Улаанбаатар гэдэг нь улам тодорхой болсоор байна. Үндсэн хуулинд "дуртай газраа амьдарч болохгүй" гэж өөрчилдөггүй л юм бол монголчууд цаашид энд улам л нэмэгдэж ирсээр байх болно. Сүүлийн гурван жилд хоёр аймагтай тэнцэх хүн бүрмөсөн нүүж иржээ. Буцаж хөдөөлсөн нь тун цөөхөн ба гадагшлахдаа тулбал гадаадыг л зорьдог аж.

Утаатай, түгжрэлтэй, хармайны хулгайчтай орчин цагийн муухай Улаанбаатарт монголчууд цөмөөр цөмөөрөө яах гэж шаваад байдаг юм бол. Хотыг хичнээн мууллаа ч бодит байдлаа эргээд харцгаая. Хөдөө цэвэр агаарт, ориг цагаан идээн дээр, амар тайван амьдарч буй үе тэнгийнхэн маань биднээс түрүүлж оворжин, өвчилж, тэгээд зогсохгүй амьдрал нь улам доройтож явна. Тэгвэл үе тэнгийн хотын хүүхэн чинь ямар байна. Амьдрах газраа сонгох эхний дур хүсэл эндээс л эхэлдэг байх.

Төрийн түшээд сонгогдсон хөдөө рүүгээ засгийн төсвийг хуу хаман зөөж байхад хотын түшээд улам нэвсийх Улаанбаатарыг додомдох гэж үйлээ үзэж сууна. Эзгүйрсэн хээр болоод байгаа нутагт зам тавьж, тог татаж, сургууль барьж өгсөөр байхад хүмүүс тогтохгүй хаячихаад иржээ. Хотод ирсэн хүн эхэндээ багтаж ядан, багтарч бөглөрч байснаа төд удалгүй олон дунд уусан шингэнэ.

Анх удаа ирсэн атигар нүүдэлчин андашгүй. Таадайгаад явган хүний замаар зөрөх зай олгохгүй хазагнан тээглэхдэг. Цаашид бага багаар суралцан гудамжинд нусаа нийх, хашаа руу шээх хоёроос бусдаар түрүүлж ирсэнээсээ ялгарахаа байдаг. Хотын хүн болж байгаа нь тэр.

Урилгагүй зочноо улаанбаатарчууд хадаг барин тосч аваагүй ч ад үзээгүй шүү. Адаглаад хүүхдийг нь төсвөө танан байж автобусанд хямд суулган зөөхөөс өгсүүлээд ажилтай, амьдралтай, адаг сүүлд нь орон сууцтай болгох гэж байна.

1950-иад оны сүүлээр хөдөөд "Атрын аян" эхэлж байсантай зэрэгцээд нийслэлд суурьшлын аян болсон байдаг. Эцсийн үр дүнд өнөөдөр хөдөө нь атаршиж, хотынхон нь соёлжсон. Гэр хорооллыг хусч "дөч, тавин мянгат"-ын орон сууц боссон.

Одоо тэгвэл Г.Мөнхбаяр даргын үед хоёр дахь давалгаа эхэлчихжээ. 2015, 2020 он гэхэд ийм болно гэсэн сайн зураг төсөөлөл гаргасан байна. Түгжрэл ба утааны сэдвээр бүгд чалчиж байхад "Ногоон нуур"-ын шаварт байгаа айлуудтай хотын удирдлага улаан гараараа тулалдаж сууна. Төвд хамгийн ойрхон гэр хороолол, түүнээс олгойдох утаа эндээс эхэлдэг. Эхний ээлжинд энэ утааг холдуулахын тулд "Дэнжийн мянга"-ын доод хүрээс зүүн тийш "Зуун айл"-ын барилгын захын замын баруун тал хүртэлх тойрог дотор байгаа зуух яндантай айлуудтай "наймаа" хийсэн байна.

Өнгөрдөг гурван сараас энэ ажиллагаа эхэлсэн гэнэ. Энэ ажлыг нийслэлийн хурлын төлөөлөгч П.Ганбаатар тэргүүтэй хэдэн залуучууд гардан хийдэг аж. Газрыг чинь зах зээлийн үнээр худалдаж авъя, дээр нь байгаа байшинг нь бас үнэлнэ. Гэхдээ хашаа, байшин, гэрээ өөрсдөө аваарай гэсэн юм байна.

Газар хааш хаашаагаа метр тутамд 100 мянган төгрөг. Байшин нь мод, тоосго, юунаас бүтсэнээс хамаарч тогтсон жишиг үнэ гаргасан. Тэр дагуугаа зүтгүүлсээр одоо ямар ч байсан зуугаад айлын газрыг аваад торон хашаанд хийгээд авч. Ингэж торлохгүй бол

арай гэж авсан газар дээр нь "нэг хөдөө" хүрч ирээд гэрээ барьчихдаг гэнэ шүү. Төлөвлөлтийн дагуух зам, дулаан, цэвэр бохир усны хоолой тавих газраа чөлөөлөх цаг тулчихаж. Тэр зургийн дагуух айлууд ч үндсэндээ нүүгээд дуусч байгаа юм байна. Харин нэг удган бөө хүүгийнхээ хамт гүрийгээд үлдсэн гэнэ. Удган болохоор дээд 99 тэнгэрээсээ асуудаг. Тэнгэр эцэг нь нэмж 90 сая төгрөг аваа гэдэг. Энэ мэт явдал төвөг бол наад захын асуудал.

Ногоон нуурын намгаас нүүж байгаа В.Баттулгынхаар орлоо. Тэднийх хоттой тохиролцож газраа жар, байшингаа гучин саяд үнэлүүлжээ. Тэгээд Х хороололд гурван өрөө байр худалдаж авчээ. Одоогоос 17 жилийн өмнө энд 800 мянгаар хашаа байшин авч төвхнөж байлаа. Уг гарвал Архангайнх. Одоо тогтсон ажил төрөлгүй. Хүүхдүүдээ шинээр авсан орон сууцандаа орхиод өөрсдөө энэ хашаа байшингаа ачаад "Үйлдвэр комбинат"-ын тэнд айлын гадаа зөөж байгаа. Яваандаа хотын захад нэг газар олоод хавраас хашаа байшингаа барьж төвхнөнө гэлээ.

Суваг ухах шугаманд ороогүй ч угаасаа газарт орсон Сүх дүүргийн гэр хорооллынхонд зориулж 15 давхар хоёр орон сууц "32-н тойрог"-ийн урд харалдаа бариад дуусч байна. Барилгын "Бэрэн" гэдэг компани бариад шинэ жилээс өмнө өгчихнө гэж инженер Лхагва хэлэв. Тэр байшин нь дандаа нэг өрөө юм билээ. Энэ хавийн газраа худалдсан айлууд ийшээ түр орогнож жинхэнэ орон сууц хэзээ барьж дуусахыг нь хүлээцгээнэ. "Ногоон нуур"-ын хүр зүүн талаасаа эхлэн өндөр гоё барилга баригдан, сургууль цэцэрлэг, хиймэл нуур, түгжрэлгүй зам тавигдаад эхэлмэгц газраа өгч гийгүүлэгсэд буцаад очих аж.

Энэ хавьд "Аман хуур" кинон дээр гардаг шиг юм юм л болж байна. Нэг нөхөр "Мебелийн үйлдвэр" гээд томоо байшин барьчихсан. Тэрнийгээ их өндөр үнэ хэлээд таг хэвтчихсэн. Уг нь шинээр баригдах энэ ҮИИ хороолол гэдэгт зөндөө олон үйлчилгээний барилга төлөвлөгдсөн нь тодорхой. Тэрнээс давуу эрхээрээ өөртөө таарсан хувь авч болохоор. Чухам тэр цагт "Ардын засаг нь ч ямар байх юм, амбан шараа өгчихөөд хожих уу яахав" гээд ацан шалаанд орчихжээ.

Одоо бол одоогийн хотын захиргаанд найдахаас өөр ямар ч сонголт байхгүй. Хотынхон ч дүүрсэн хэрэг гэгчээр гэр хорооллынхон руу ханцуй шамлаад орчихож. Тэдний ярьж байгаагаар бусад бүх дүүрэгт ийм ажиллагаа эхлээд байгаа гэнэ. Бүр Налайх, Багахангайд ч зураг төсөл хийгдсэн. Ирэх жилээс бүх татвараа улсад өгөлгүй өөр дээрээ төвлөрүүлж хотдоо зориулахаар төр засагтай тохиролцож байгаа гэж Г.Мөнхбаяр мэр хэлж байна.

Хотоос босдог хамаг татвар улсын нэг тогоонд орж бусад аймгууд руу татаасанд оддог байсныг болиулах гэнэ. Одоо л Улаанбаатар маань хот шиг хот болох гэж байгаа юм байна ш дээ.

Дулаан цаг ирмэгц гудамжаар энд тэндгүй шуудуу ухан шугам траншей солиод эхэлдэг дээ. Тэгвэл "дөчин мянгат" хавиас эхлэн түрүүчээсээ тэгэхээ больж байгаа юм байна. Газар доогуур урт хонгил бариад хананд нь халуун, хүйтэн, бохир усны трубанууд, цахилгаан, шилэн кабелийн бүх утас шөрмөсүүдийг бүгдийг нь тэр нүх рүү чихжээ. Энэ хавьд л лав амар болж. Уугуул оршин суугчдын ярьж байгаагаар 1950 оноос хойш зөвхөн бохирын хоолойг солих гэж дөрвөн удаа ухаж байсан, за тэгээд бусад судас шөрмөсүүдийг мөн тэр тоолонгоор сольж засч байсныг тоолохоор бараг зун болгон л хүүхэд үүхэд нисгэхээ алдсан нүхнүүдтэй байсаар ирсэн гэнэ.

Одоо цаашид бүх засварын ажлыг хонгил дотуур сүвлээд, газар сэндчих асуудалтай болжээ. Мөнхбаяр их зөв ажил эхлүүлчихлээ гэчихжээ. Энэ дашрамд бас нэг ажил

амжуулсан нь жорлон "паар" хоёроор ундны цэвэр ус гоожуулж тансаглахыг болиулж тусад нь труба татаж байгаа гэнэ шүү. Яваандаа Улаанбаатар цэвэр усны хомсдолд орох цагт энэ нь аминд орох аж. Хожим хот даяараа хонгилтой болоод ирэхийн цагт траншейд амьдардаг хүмүүс орох оронгүй болчих байхдаа. За тэр ч яахав. Мөнхбаяр даргаас "Энэ Нисэхийн, Налайхын, Долоон буудлаас хойших гэсэн гурван том түгжрэлийг яах гэж байна?" гэхэд

- Сая арай гэж хот доторх донсолгоог янзаллаа. Наад гурвыг чинь "22-н товчоо" шиг өргөн болгоно. Хавар дулаармагц эхэлнэ. Нисэх, Яармагийг нөгөө "Мянганы сорил"-ынхон Америкийн мөнгөөр барихаар шийдчихсэн байгаа гэлээ.

Хот доторхи сонин сонин объектуудын учрыг сонирхлоо. "Зүчи" гээд зочид буудал байсан өндөр балгас "Буян" Жагаад хэвээрээ байгаа агаад хувийн өмч учир яах гэж байгааг нь мэдэхгүй гэж байна. Харин Х хороолол дахь спорт цогцолбор барих гээд орхисон арзайсан төмөр рамны талыг нь тэр жил зарсан. Одоогийн "UB палас". Үлдсэнийг нь хэзээ мөдгүй дуудлагаар оруулахаар бэлдээд байгаа. Гэхдээ нэг болзол бий. Тэр төмөр рамыг ашиглаж барилга барьж болохгүй. Маралын элэгдэлд ороод аюултай болсон гэнэ. Хотын төвд байгаа нөгөө алдарт хэвлэх үйлдвэрийн барилга мөн дуудлагад орно гэнэ. Гэхдээ дуудахаас өмнө Их Хуралд хандаж нөгөө парламентын ордноо энд барьчихаач ээ. Ордны хойд талын хайран цэцэрлэгийг сүйтгэж байхаар энд бэлэн газар байна гэсэн гэнэ. Их мөнгөөр зураг хийлгэсэн юм чинь одоо яаж буцаж наана чинь барих шийдвэр гаргах юм. Адаглаад л дахиад зураг хөрөг гаргах зэрэг зардлын төвөг гээд зөвшөөрөхгүй байгаа аж. Харин дотор нь байсан "Улаанбаатар таймс" сонины зөвхөн эрхийг сэтгүүлч Дагиймаад зарсан юм байна. Тэрнээс газартай нь өгчихөөгүй юм байна.

Хотын түгжрэлийн хувьд яваандаа гадаадаас зөвхөн шинэ машин оруулж ирдэг жишиг рүү л шилжих сурагтай. Хэн дуртай нь "эксел"-тэй пижигнүүлж явдаг, дурын газраа машинаа зогсоодог зогсоол энэ тэр том төлбөрт үйлчилгээнд шилжих юм байх. Вагоноор орж ирдэг ачаа таворыг хотын зүүнтэйх Хонхорын зөрлөг дээр буулгадаг болох гэнэ. Тэнд буусан ачаа хэрэв баруун зүг тээвэрлэгдэх бол урдуур Төв аймгаар тойрч явах зэргээр том даацын машин ба ачаанууд холдоно. Одооны аварга машинууд зуугаас дээш тонн ачаа ачдаг. Тэрнийг урьд нь тооцож байгаагүйгээс манай социализмын үед барьсан замууд даахгүй шөнөдөө зам эвдээд хаячихдагийг мэдэж авчээ. Нэгэнт ачаа Хонхорт төвлөрөөд эхлэхээр Эрээнээс ирэх бараа ч тэнд бууж "Нарантуул" шиг захууд бий болно. Түгжрэлийн голомт болсон захууд аяндаа тийшээ нүүх нь тодорхой гэж үзэж байна.

Утааг бишгүй л ярьж байгаа. Яг утаатай тэмцэх хөрөнгө төсөв нь Байгаль орчны яам, Эрчим хүчний яам зэрэг бусад байгууллагад төвлөрсөн байдаг болохоос хотод май гээд өгсөн мөнгө одоо хүртэл байдаггүй. Манайх л хамаг муугаараа дуудуулж суудаг. Би өөрөө ч утааны яг голомт Тасганы овооны харалдаа орон сууцанд амьдардаг гэж Билэгт дарга инээж сууна. Харин маш олон усан оргилуур барьж байгаа. Цаашдаа ч нэмж байгуулна. Энэ нь хотыг бага ч атугай чийгшүүлж машины нагаарыг дарах цаад зорилго давхар яваа юм. Мэдээж гадна тохижилт, соёл амралтад зориулагдсан ажил.

Хаа байсан Манжийн үед сүүлчийн амбан Сандо Их Хүрээнд анх жорлон санаачилж байсан гэдэг. Тэрнээс хойш боловсон бие засах арга хэмжээ авах нь авсаан. Гэхдээ хүн амын өсөлттэйгээ жиших юм бол дандаа хоцрогдож хаягдаж байсан манай нэг ноцтой гажуудал явдаг. Энэ жилээс энд тэндгүй жорлон бариад эхэллээ. "Хааны албанаас

хасын алба хэцүү" гэж ярьдаг. Ялихгүй юм шиг атлаа энэ их чухал зүйл байсан байна. Бүр хотын нэн тэргүүнд шийдэх асуудал хэмээн ач холбогдол өгснийг олон нийт сая л анзаарч хашаа руу сарихаа больж, жорлон нэхэх болжээ.

Автобусны эцсийн зогсоол янзын гоё болсныг үзээрэй гэсний дагуу очих зэргээр Улаанбаатарт ямар бүтээн байгуулалт болж буйг хоёр өдөр явж сурвалжиллаа. Монголчууд бараг бүгдээрээ нэг дор амьдарч байгаа энэ их хот маань өөдрөг сэтгэгдэл төрөх зөв өнгөндөө орчихож.

Бид одоо хааяа салхинд гарахыг эс тооцвол дахиж хөдөө нутаг руугаа явж амьдрахаасаа өнгөрсөн байх аа. Лав л үр хүүхэд маань юу ч амалсан хөдөө байтугай зуслангийн лагер дээр ч очихгүй юм байна шүү дээ.

Тэгэхээр одоо цөмөөрөө хот руугаа анхаарлаа хандуулж эндээ бүрмөсөн тохижиж авах арга бодоцгоох нь дээр биз дээ.

Мянга хүрэхгүй хүнтэй суманд маань яасан ч олон төрийн албан хаагч байдаг юм. Арван мянга, хорин мянгуулаа амьдарч байгаа хороо маань энэ их асуудлыг хэдүүлхнээ амжуулж суугаа нь бас бодууштай. Энэ жил ачааллаа дийлэхээ болиод хэдэн хороо нэмлээ гэнэ. Хойтонгоос хоёр гурван дүүрэг ч шинээр төрөх сурагтай. Жилдээ нэг аймаг нүүж ирж байгаа энэ хонхорт тэгэхээс өөр яадаг юм.

Нэгэнт бид энэ нутгийн суугуул, уугуул иргэд болж байгаа юм чинь хороондоо дугаар биш нэр өгч тэр нэрээрээ алдаршиж явах нь дээр байх гэж Билэгт дарга хэлж байна. Тэгэхээр нь "Харин ээ. Танай жишгээр тэд дугаар аймгийн төд дугаар сум гэж байвал яасан юм" хэмээн зарчмын санал гаргаж хөхрөлдөцгөөв.

Хотын мэр Г.Мөнхбаяраас "Томцуул голдуу бие хамгаалагчтай олноос далд амьдардаг. Юм гуйна гээд барагтай бол олддоггүй. Гэтэл та заримдаа гудамжинд гараа хармайндаа хийчихсэн явган алхаж яваа харагддаг юм. Хүмүүс танаас гэр орноос өгсүүлээд шил архины мөнгө гуйгаад төвөгтэй биш үү?" гэхэд "Яг манай хотын иргэд бол тааралдахаараа гар бариад, одоо хотыг тэгмээр байна гэсэн санал голцуу солилцдог. Улаанбаатарын дундаж иргэд бол өөр ш дээ" гэсэн юм. Монголын хамаг ядуус энд цугларсан хэдий ч ийм л байх юмсан гэх олон мөрөөдлийн зах зухыг Улаанбаатар л үзүүлж эхэлсэний нэг жишээ тэр биз ээ.

Улаанбаатарын хөгжил, амьдрах орчин, засаглал, хууль эрхзүй хойшид ямар байх нь Монголоос ч чухал асуудал болсоор байна.

Мэдээллийн эх сурвалж: bolod.mn


ooOoo

АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Зураг 1. Аж ахуйн нэгж, байгууллагын тоо


Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 70.6 хувь, үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагын 65.6 хувь нь нийслэл хотод байршдаг.

Нийслэл хотод 2010 онд үйл ажиллагаа явуулахаар 53627 аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлсэн байна. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 50.1 хувь буюу 26851 нь жилийн турш байнга үйл ажиллагаа явуулжээ.



Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 49.9 хувь буюу 26776 нь 2010 онд үйл ажиллагаа явуулаагүй байна. Эдгээр ААНБ-ын 27.1 хувь нь 2010 онд үйл ажиллагаа эхэлж чадаагүй, 37.7 хувь нь үйл ажиллагаа түр зогсоосон, 2.3 хувь нь бүрэн зогсож, 32.9 хувь нь бусад шалтгаанаар үйл ажиллагаа явуулж чадаагүй байна.

Зураг 2. Нийслэлийн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, оноор




Нийслэл хотод бүртгэлтэй ААНБ-ын 2.3 хувь нь төрийн өмчийн, 0.1 хувь нь орон нутгийн өмчийн, 97.6 хувь буюу 52371 ААНБ хувийн эзэмшилд байна. Хувийн өмчийн ААНБ-ын 5.4 хувь нь гадаадтай хамтарсан, 7.0 хувь нь гадаадын иргэний өмчлөлд байна.

Хүснэгт 1. Нийслэлийн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хариуцлагын хэлбэрээр


	2004 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Компани	14850	18695	25179	29926	34454	36349	44833
Нөхөрлөл	1671	1797	1879	1877	1494	1498	1489
Хоршоо	743	911	1054	1056	848	851	853
Улсын үйлдвэрийн газар	177	164	159	159	153	154	156
Төсөвт байгууллага	813	809	835	893	894	894	1065
Төрийн бус байгууллага	2709	2706	3764	4275	5072	5120	5160
Бусад	-	-	9	156	73	71	71
Бүгд	20933	25082	32879	38342	42988	44937	53627

Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 21.1 хувь нь Баянгол, 19.8 хувь нь Баянзүрх, 19.0 хувь нь Сүхбаатар, 17.3 хувь нь Чингэлтэй, 14.3 хувь нь Сонгинохайрхан, 6.2 хувь нь Хан-Уул, 1.4 хувь нь Налайх, 0.8 хувь нь Багануур, 0.1 хувь буюу 19 нь Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг. Эдгээр ААНБ-ын 89.1 хувь буюу 23929 нь 1-ээс 9 ажиллагчидтай бол 4.8 хувь нь 10-19, 3.5 хувь нь 20-49, үлдсэн 2.6 хувь буюу 700 аж ахуй нэгж нь 50-аас дээш тооны ажиллагчидтай байна.

Зураг 3. Үйл ажиллагаа явуулж буй ААНБ, байршлаар



Зураг 4. Үйл ажиллагаа явуулж буй ААНБ, байршил, ажиллагчдын тоогоор



Хүснэгт 2. Аж ахуйн нэгж, байгууллага, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байршлаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүртгэлтэй ААНБ-ын тоо	Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ	Үйл ажиллагаа явуулж буй ААНБ, байршлаар								
			Багахангай	Багануур	Баянгол	Баянзүрх	Налайх	Сүхбаатар	Сонгино хайрхан	Чингэлтэй	Хан-Уул
БҮГД	53627	26851	19	219	5662	5321	386	5100	3849	4644	1651
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур	852	397	0	7	68	76	6	48	111	39	42
Уул уурхай, олборлох үйлдвэр	621	282	0	3	54	56	28	53	38	41	9
Боловсруулах үйлдвэр	3243	1619	1	18	346	313	25	299	267	195	155
Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж	77	44	1	2	13	7	2	3	3	6	7
Барилга	2418	1075	0	7	244	173	9	155	214	190	83
Бөөний, жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	29486	15261	5	66	3333	3280	169	2752	2363	2538	755
Зочид буудал, зоогийн газар	1414	817	0	9	206	98	36	149	97	167	55
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	1874	797	1	3	161	152	6	139	86	170	79
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	1393	821	0	29	169	118	9	211	76	196	13
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	4275	1999	0	11	306	450	20	428	205	412	167
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал	379	333	5	14	23	42	15	66	31	105	32
Боловсрол	1140	847	2	14	139	137	17	252	101	102	83
Эрүүл мэнд, нийгмийн халамж	996	775	2	18	160	155	17	161	110	91	61
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	5450	1780	2	18	440	261	27	384	147	391	110
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	9	4	0	0	0	3	0	0	0	1	0

Хүснэгт 3. ААНБ-ын тоо, хариуцлагын хэлбэр, үйл ажиллагаа эрхлэлтээр

Байгууллагын хэлбэр	Бүгд	Үүнээс					
		Үйл ажиллагаа явуулж байгаа	Үйл ажиллагаа явуулаагүй	Үүнээс үйл ажиллагаа:			
				Эхлээгүй	Түр зогсоосон	Бүрэн зогсоосон	Бусад
Хувьцаат компани	141	105	36	1	26	4	5
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	44692	22753	21939	7145	7906	375	6513
Төрийн өмчит үйлдвэрийн газар	129	84	45	2	15	3	25
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	27	19	8		5		3
Хоршоо	853	395	458	49	197	26	186
Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	608	299	309	20	161	5	123
Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	881	449	432	25	215	28	164
Төсөвт байгууллага	1065	986	79		25	3	51
Төрийн бус байгууллага	5160	1705	3455	10	1538	178	1729
Бусад	71	56	15	2	5		8
Дүн	53627	26851	26776	7254	10093	622	8807

Хүснэгт 4. Үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо, ажиллагчдын тооны бүлгээр


Дүүрэг	Бүгд	Үүнээс ажиллагчдын тооны бүлгээр			
		0-9	10-19	20-49	50+
Багануур	219	164	24	14	17
Багахангай	19	11	1	6	1
Баянгол	5662	5096	292	177	97
Баянзүрх	5321	4811	250	148	112
Налайх	386	335	19	12	20
Сонгинохайрхан	3849	3529	150	110	60
Сүхбаатар	5100	4514	224	194	168
Хан-Уул	1651	1321	99	122	109
Чингэлтэй	4644	4148	227	153	116
Дүн	26851	23929	1286	936	700

ХОТЫН ЭДИЙН ЗАСАГ

Нийслэл хотын эдийн засаг 2010 оны үнээр 5225.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 33.5 хувиар өссөн байна. Монгол улсын 2010 оны дотоодын нийт бүтээгдэхүүний 62.1 хувийг нийслэл хот бүрдүүлжээ.

Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 50.3 хувийг Улаанбаатар хот 2000 онд бүрдүүлж байсан бол 2005 онд 54.0 хувь болж 3.7 пунктээр өсч, харин 2007 онд 51.2 хувь болж, 2005, 2006 оныхоос буурсан байна. Улсын ДНБ-ний дүнд Улаанбаатарын эзлэх хувь хэмжээ буурсан нь тухайн үед Орхон, Сүхбаатар зэрэг бусад аймгийн нэмүү өртгийн хэмжээ өсч байснаас голлон шалтгаалжээ.


Зураг 5. УБ бүсийн Монгол улсын эдийн засагт эзлэх хувь



Дотоодын нийт бүтээгдэхүүнд Улаанбаатар бүсийн эзлэх хувь 2010 онд 62.1 хувь болж, 2009 оныхоос 2.7 пунктээр нэмэгдсэн байна. Бусад бүсийн ДНБ-д эзлэх хувийн жин 2010 онд 3.5-19.1 хувь байгаа нь 2009 оныхоос 0.5-1.2 пунктээр буурсан байна.

Бүс, аймгийн ДНБ-ий (оны үнээрх) 2010 оны гүйцэтгэлийг 2009 оныхтой харьцуулбал баруун бүсийнх 1.3 хувь, хангайн бүсийнх 23.8 хувь, төвийн бүсийнх 22.8 хувь, зүүн бүсийнх 11.4 хувь, Улаанбаатарынх 33.5 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 6. ДНБ-ний өсөлт, бүсээр, оны үнээр



Хүснэгт 5. ДНБ-ий 2005-2010 оны гүйцэтгэл, оны үнээр, бүс, аймгаар,

	ДНБ, тэрбум төгрөгөөр						<u>2010%</u> <u>2009</u>
	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он	
Баруун бүс	219.6	271.4	342.5	480.6	377.1	381.9	101.3
Баян-Өлгий	42.7	50.1	60.4	84.7	69.9	82.2	117.6
Говь-Алтай	31.8	46.6	55.7	75.0	62.8	49.2	78.4
Завхан	44.2	56.9	74.4	111.9	82.1	72.9	88.8
Увс	46.5	55.1	71.1	93.2	75.9	83.4	109.9
Ховд	54.4	62.8	80.9	115.8	86.4	94.1	108.9
Хангайн бүс	635.9	988.5	1 338.8	1 475.0	1 299.0	1 608.6	123.8
Архангай	62.8	69.4	93.9	147.3	142.7	133.0	93.2
Баянхонгор	47.9	50.2	63.2	103.7	89.3	80.5	90.1
Булган	40.6	50.8	67.0	108.4	112.4	121.6	108.2
Өвөрхангай	58.1	64.3	84.3	116.8	121.0	103.8	85.8
Хөвсгөл	71.9	81.2	110.8	170.6	154.8	162.1	104.7
Орхон	354.5	672.7	919.6	828.1	678.7	1 007.6	148.5
Төвийн бүс	298.2	369.0	468.1	725.1	736.1	903.6	122.8
Дорноговь	28.5	22.0	27.8	53.3	55.1	61.1	110.9
Дундговь	38.1	39.5	42.7	58.9	53.2	54.2	102.0
Өмнөговь	47.9	60.6	83.0	110.4	141.7	222.6	157.1
Сэлэнгэ	58.4	101.4	132.4	208.3	189.2	193.9	102.5
Төв	59.8	74.3	91.2	139.3	151.0	157.5	104.3
Дархан-Уул	54.9	59.7	82.7	135.4	127.4	184.6	144.9
Говьсүмбэр	10.4	11.5	8.3	19.5	18.5	29.6	160.2
Зүүн бүс	125.7	225.3	271.5	279.9	264.5	294.6	111.4
Дорнод	38.7	42.2	60.2	80.9	77.4	74.7	96.5
Сүхбаатар	43.4	132.8	149.9	116.3	111.7	133.1	119.1
Хэнтий	43.6	50.3	61.5	82.7	75.3	86.8	115.2
Улаанбаатар	1 762.0	2 173.4	2 535.8	3 595.0	3 913.9	5 225.9	133.5
Бүгд	3 041.4	4 027.6	4 956.6	6 555.6	6 590.6	8 414.5	127.7

Хүснэгт 6. ДНБ-д бүсийн эзлэх хувийн жин, 2005-2010 он, бүс, аймгаар

	Дүнд эзлэх хувь					
	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Баруун бүс	7.2	6.7	6.9	7.3	5.7	4.5
Баян-Өлгий	1.4	1.2	1.2	1.3	1.1	1.0
Говь-Алтай	1.0	1.2	1.1	1.1	1.0	0.6
Завхан	1.5	1.4	1.5	1.7	1.2	0.9
Увс	1.5	1.4	1.4	1.4	1.2	1.0
Ховд	1.8	1.6	1.6	1.8	1.3	1.1
Хангайн бүс	20.9	24.5	27.0	22.5	19.7	19.1
Архангай	2.1	1.7	1.9	2.2	2.2	1.6
Баянхонгор	1.6	1.2	1.3	1.6	1.4	1.0
Булган	1.3	1.3	1.4	1.7	1.7	1.4
Өвөрхангай	1.9	1.6	1.7	1.8	1.8	1.2
Хөвсгөл	2.4	2.0	2.2	2.6	2.3	1.9
Орхон	11.7	16.7	18.6	12.6	10.3	12.0
Төвийн бүс	9.8	9.2	9.4	11.1	11.2	10.7
Дорноговь	0.9	0.5	0.6	0.8	0.8	0.7
Дундговь	1.3	1.0	0.9	0.9	0.8	0.6
Өмнөговь	1.6	1.5	1.7	1.7	2.1	2.6
Сэлэнгэ	1.9	2.5	2.7	3.2	2.9	2.3
Төв	2.0	1.8	1.8	2.1	2.3	1.9
Дархан-Уул	1.8	1.5	1.7	2.1	1.9	2.2
Говьсүмбэр	0.3	0.3	0.2	0.3	0.3	0.4
Зүүн бүс	4.1	5.6	5.5	4.3	4.0	3.5
Дорнод	1.3	1.0	1.2	1.2	1.2	0.9
Сүхбаатар	1.4	3.3	3.0	1.8	1.7	1.6
Хэнтий	1.4	1.2	1.2	1.3	1.1	1.0
Улаанбаатар	57.9	54.0	51.2	54.8	59.4	62.1
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

ДНБ-ий салбарын бүтцийг бүсээр харьцуулбал, баруун бүсэд хөдөө аж ахуй, хангайн бүсэд үйлдвэрлэл, Улаанбаатарт үйлчилгээний салбар зонхилж байна.

Нийслэл хотын эдийн засгийн 64.9 хувийг үйлчилгээний, 34.6 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 0.5 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлдэг.

Хүснэгт 7. Нийслэл хотын эдийн засгийн бүтэц, хувиар

Эдийн засгийн үйл ажиллагаа	2005 ОН	2006 ОН	2007 ОН	2008 ОН	2009 ОН	2010 ОН
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.3	0.3	0.3	0.3	0.4	0.3
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.6	0.5	0.5	0.5	0.5	0.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.8	0.8	0.8	0.7	0.5	0.4
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.7	0.7	0.7	0.7	0.7	0.5
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1.2	1.2	1.1	1.1	1.1	0.9
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.9	1.1	1.4	2.0	1.4	1.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.0	1.1	1.5	1.6	1.6	1.5
Барилга	4.2	3.9	4.5	3.7	2.2	2.2
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.0	1.6	2.1	2.8	2.3	2.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	4.0	3.7	3.2	2.8	3.5	2.8
Боловсрол	2.5	2.9	3.3	3.6	4.1	3.3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2.8	4.3	4.2	4.8	5.1	4.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5.1	4.5	5.1	5.5	4.7	4.5
Мэдээлэл, холбоо	6.4	5.7	7.2	6.9	6.4	5.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	6.5	6.0	5.6	6.1	9.8	8.2
Боловсруулах үйлдвэрлэл	10.7	9.7	10.9	11.6	11.5	10.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	12.7	11.7	11.1	9.6	11.2	11.3
Уул уурхай, олборлолт	15.7	18.3	14.3	13.7	14.2	16.3
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	21.9	22.1	22.3	22.0	18.7	23.6
Бүгд	100	100	100	100	100	100


Нийслэлийн эдийн засагт бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, олборлолт, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа хамгийн их эзлэх хувийн жинтэй байна.

Нийслэл хотын эдийн засгийн 82.7 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд бүтээж байна.

Хүснэгт 8. Нийслэлийн эдийн засагт хувийн хэвшлийн оролцоо, хувиар

Эдийн засгийн үйл ажиллагаа	Тухайн салбарт хувийн хэвшлийн эзлэх хувийн жин					
	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	99.8	99.9	99.9	99.8	99.9	100.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	100.0	99.9	99.8	98.2	98.4	100.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	99.1	98.8	98.2	98.1	98.8	99.2
Боловсруулах үйлдвэрлэл	94.1	93.0	96.3	98.6	98.7	99.2
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	99.4	98.2	99.4	98.4	99.8	97.9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	90.7	84.1	83.7	94.2	112.9	97.4
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	99.8	99.5	99.4	98.9	99.4	97.3
Барилга	83.4	90.2	97.0	96.8	98.1	97.2
Уул уурхай, олборлолт	93.3	93.1	92.6	91.4	92.7	93.7
Мэдээлэл, холбоо	87.0	85.8	85.6	92.0	94.6	91.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	45.2	46.3	48.7	59.2	58.9	65.7
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	69.6	70.9	60.8	63.6	70.4	63.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	62.4	59.6	41.2	40.6	59.9	50.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	15.1	15.8	20.1	18.3	25.4	33.8
Боловсрол	28.8	31.3	25.3	19.0	27.5	21.9
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	30.7	40.7	40.8	27.6	37.3	16.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	20.4	23.2	15.9	16.1	16.8	0.9
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бүгд	79.9	79.1	79.3	80.9	81.2	82.7

Зураг 7. Нэг хүнд ногдох ДНБ, мянган төгрөг



Нийслэлийн нэг хүнд ногдох нэмүү өртөг 2010 онд 4.6 сая төгрөг болж, өмнөх оныхоос нэг сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь улсын дунджаас 1.5 сая төгрөгөөр илүү байна.

Монгол улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 онд 3.1 сая төгрөг болж, 2009 оноос 700 гаруй мянган төгрөгөөр нэмэгджээ.

Хүснэгт 9. Нэг хүнд ногдох ДНБ, нийслэл, аймгаар, (оны үнээр, мян.төг)

	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Баруун бүс	535.0	662.7	834.1	1 171.9	923.2	942.3
Баян-Өлгий	424.1	500.6	600.9	837.8	688.3	811.2
Говь-Алтай	523.2	771.4	924.4	1 249.9	1 053.4	835.9
Завхан	549.9	707.9	919.4	1 391.1	1 031.9	933.9
Увс	575.5	683.6	883.3	1 163.5	957.5	1 062.9
Ховд	619.4	711.7	914.5	1 308.7	976.7	1 063.7
Хангайн бүс	1 151.8	1 788.4	2 413.4	2 642.5	2 308.3	2 841.9
Архангай	665.9	741.6	1 009.3	1 589.6	1 543.5	1 445.0
Баянхонгор	572.5	599.8	752.0	1 224.9	1 047.6	943.8
Булган	672.5	845.3	1 108.6	1 777.9	1 816.3	1 945.7
Өвөрхангай	512.3	562.5	731.5	1 006.1	1 034.2	884.1
Хөвсгөл	591.8	666.0	906.4	1 390.6	1 252.9	1 303.2
Орхон	4 503.4	8 490.9	11 528.6	10 221.2	8 222.7	11 932.7
Төвийн бүс	681.6	845.6	1 070.5	1 647.0	1 648.2	1 986.4
Дорноговь	539.4	408.1	503.9	944.5	953.4	1 037.0
Дундговь	766.3	799.6	871.6	1 213.8	1 108.4	1 153.3
Өмнөговь	1 032.5	1 308.5	1 777.2	2 333.9	2 919.9	4 436.4
Сэлэнгэ	582.3	1 014.5	1 319.9	2 061.9	1 846.1	1 847.0
Төв	678.8	854.9	1 058.1	1 612.9	1 723.3	1 762.9
Дархан-Уул	626.1	681.4	944.6	1 540.6	1 429.9	2 031.3
Говьсүмбэр	851.7	937.9	670.9	1 533.1	1 411.4	2 185.7
Зүүн бүс	626.0	1 125.4	1 359.5	1 403.6	1 323.9	1 471.3
Дорнод	525.5	573.7	822.0	1 104.0	1 051.9	1 014.7
Сүхбаатар	771.6	2 380.2	2 707.8	2 113.2	2 033.6	2 420.6
Хэнтий	614.9	710.1	863.8	1 163.2	1 057.5	1 211.8
Улаанбаатар	1 860.8	2 218.3	2 503.9	3 419.2	3 584.1	4 616.9
Монгол улс	1 193.8	1 561.9	1 895.5	2 465.1	2 432.3	3 050.6

Нийслэл хотын эдийн засагт 2010 онд 1779.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Хөрөнгө оруулалтын хэмжээ 2009 оныхоос 2.2 дахин 984.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт хөрөнгө оруулалтын 72.4 хувийг гадаадын, 27.6 хувийг дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байна. 2010 онд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос 3.6 дахин, дотоодын хөрөнгө оруулалт 12.7 хувиар өсчээ.

Хүснэгт 10. Хөрөнгө оруулалтын бүтэц, санхүүжилтийн эх үүсвэрээр, оны үнээр

Эх үүсвэр	Хөрөнгө оруулалт, тэрбум төг			Хөрөнгө оруулалтын бүтэц, хувиар		
	2008 он	2009 он	2010 он	2008 он	2009 он	2010 он
Хөрөнгө оруулалт, бүгд	767.6	794.8	1779.3	100.0	100.0	100.0
1.Дотоодын хөрөнгө оруулалт	190.9	436.4	491.8	24.9	54.9	27.6
Улсын төсөв	40.4	15.4	41.1	5.3	1.9	2.3
Орон нутгийн төсөв	15.2	19.2	29.2	2.0	2.4	1.6
Монгол улсыг хөгжүүлэх сан	0.0	14.5	0.0	0.0	1.8	0.0
Бусад /өөрийн хөрөнгөөр/	135.3	387.3	421.5	17.6	48.7	23.7
2.Гадаадын хөрөнгө оруулалт	576.7	358.4	1287.5	75.1	45.1	72.4
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	566.5	353.4	1270.0	73.8	44.5	71.4
Бусад /өөрийн хөрөнгөөр/	10.2	5.0	17.5	1.3	0.6	1.0

Хүснэгт 11. Нийслэлд шинээр бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-ын тоо

Улсын нэр	2009 он	2010 он
БНХАУ	299	364
БНСУ	113	116
Британи Виржини арал	23	37
Гонконг	10	27
Япон	35	23
Сингапур	4	22
Австрали	4	21
ОХУ	37	17
АНУ	11	14
Канад	9	13
Вьетнам	3	8
ХБНГУ	8	7
Малайз	5	7
Их Британи	4	5
Казахстан	1	5
Бусад орон	47	67
дүн	613	753

Нийслэлд 2010 онд үйл ажиллагаа явуулахаар шинээр бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо 753 болж, өмнөх оноос 22.8 хувиар нэмэгджээ. Шинээр бүртгэгдсэн нийт аж ахуйн нэгжийн 94.9 хувь нь нийтийн хоол, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.


Улаанбаатар хотод дэд бүтэц, зах зээлийн хүчин чадавх, мэргэжилтэй ажиллах хүчний төвлөрөл ихтэйгээс улсын нийт хөрөнгө оруулалтын ихэнх хувь нь нийслэлд зарцуулагдаж байна. Харин хөдөө нутагт дэд бүтцийн хөгжил сул, зах зээл бага, зах зээлээс алслагдмал, ихэнх хүн ам нь мал аж ахуйгаас хараат тул хөрөнгө оруулалт нийслэлтэй харьцуулахад бага юм.

НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн 2010 оны төсөвт 164.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, төсвийн орлого төлөвлөснөөс 9.7 тэрбум төгрөгөөр буюу 6.2 хувиар илүү бүрджээ. Орлогын бүрдэлт 2009 оныхоос 23.2 хувиар өссөн байна.

Төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 103.5 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын хэмжээ 56.2 тэрбум төгрөг болж, төсвийн тэнцэл 4.6 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Нийслэлийн төсвийн нийт орлогын 87.1 хувийг татварын орлого, 9.7 хувийг татварын бус орлого, 3.2 хувийг хөрөнгийн орлого тус тус эзэлж байна.

Зураг 8.Төсвийн орлого зарлага, тэрбум төгрөг



Хүснэгт 12. Нийслэлийн төсвийн орлого, дүүргээр, сая төгрөг

	Төсвийн орлого		үүнээс:					
	Бүгд	ТБ %	Татварын орлого		Татварын бус орлого		Хөрөнгийн орлого	
			Бүгд	ТБ %	Бүгд	ТБ %	Бүгд	ТБ %
Хан-Уул	7109.8	117.0	5419.9	103.6	975.8	181.4	714.1	230.7
Багануур	790.1	116.8	551.7	120.3	157.7	110.3	80.8	107.7
Баянзүрх	4108.3	106.6	2804.2	100.5	523.6	126.2	780.4	120.2
Налайх	394.2	134.2	285.3	143.6	84.3	102.8	24.7	190.0
Баянгол	3508.7	121.6	1873.1	100.8	680.8	159.8	954.7	159.1
Сүхбаатар	4790.8	120.2	3278.0	100.4	850.0	163.5	662.8	331.4
Чингэлтэй	3056.5	122.7	1752.7	112.9	1038.5	133.3	265.3	147.4
Багахангай	39.9	141.5	15.6	305.9	24.4	105.6	-	-
Сонгинохайрхан	1768.3	125.4	1042.1	129.5	346.7	107.0	379.6	134.8
Нийслэлийн шууд	138707.8	104.3	126047.9	103.2	11326.9	116.0	1332.8	133.3
Дүн	164274.4	106.2	143070.5	103.4	16008.7	123.0	5195.2	157.0

Татварын орлогын хэмжээ 143.1 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 103.5 хувиар биелсэн бөгөөд орлогын голлох төрлүүдээр авч үзвэл 71.3 хувийг хүн амын орлогын албан татвар, 6.1 хувийг өмчийн албан татвар, 4.2 хувийг бараа үйлчилгээний албан татвар, 0.4 хувийг бараа үйлчилгээний бусад татвар, 18.0 хувийг бусад төлбөр хураамж (улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, рашаан ус ашигласны төлбөр, ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын лиценз) эзэлж байна.

Хүснэгт 13. Нийслэлийн төсвийн орлогын гүйцэтгэл, 2010 онд, сая төгрөгөөр

Татварын орлогын нэр төрөл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү, сая төг
Төсвийн орлогын дүн	154635.7	164274.4	106.2	9638.7
1. Нийт татварын орлого	138312.6	143070.5	103.4	4757.9
Хүн амын орлогын албан татвар	98526.1	102094.0	103.6	3567.9
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	90168.4	92717.4	102.8	2549.0
ХХОАТ-ын буцаалт	-2688.9	-2632.7	97.9	56.2
Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний	1309.1	1226	93.7	-83.1
Хувиараа аж ахуй эрхлэгчдийн орлогын	4970.2	5437.8	109.4	467.6
Мал бүхий иргэний орлогын	0.1	1.6	1600.0	1.5
Бусад	4767.2	5343.9	112.1	576.7
Өмчийн татвар	7467.3	8682.0	116.3	1214.7
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	7437.8	8653.2	116.3	1215.4
Бууны татвар	29.5	28.8	97.6	-0.7
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	6547.5	6636.6	101.4	89.1
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	5937.1	5947.4	100.2	10.3
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	610.4	689.2	112.9	78.8
Бусад татвар, хураамж, төлбөр	25771.7	25657.9	99.6	-113.8
Улсын тэмдэгтийн хураамж	7290.1	6654.1	91.3	-636.0
Ашигт малтмалын лиценз	57.9	37.4	64.6	-20.5
Газрын төлбөр	17997.5	18348.7	102.0	351.2
Рашаан ус ашигласны төлбөр	417.2	577.9	138.5	160.7
Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны	9.0	39.8	442.2	30.8
2. Татварын бус орлогын дүн	13015.1	16008.7	123.0	2993.6
Хувьцааны ногдол ашиг	102.6	111.6	108.8	9.0
Түрээсийн орлого	931.3	772.1	82.9	-159.2
Төсөвт газрын өөрийн орлого	3995.2	5337.2	133.6	1342.0
Автозам ашигласны төлбөр	530.0	510.6	96.3	-19.4
Хүү, торгуулийн орлого	7076.5	8625.8	121.9	1549.3
Бусад нэр заагдаагүй орлого	379.5	651.4	171.6	271.9
3. Хөрөнгийн орлого	3308.0	5195.2	157.0	1887.2
Хөрөнгө худалдсаны орлого	2308.0	3862.4	167.3	1554.4
Өмч хувьчлалын орлого	1000.0	1332.8	133.3	332.8

2010 онд 13.0 тэрбум төгрөгийн татварын бус орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 16.0 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын төлөвлөгөө 123.0 хувиар биелсэн байна.

Нийт татварын бус орлогын 53.9 хувийг хүү, торгуулийн орлого, 33.3 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 12.8 хувийг ААНБ-ын ногдол ашиг болон бусад орлогууд бүрдүүлжээ. Харин хөрөнгийн орлогын хэмжээ 5.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.9 тэрбум төгрөгөөр буюу 57.0 хувиар илүү бүрдсэн байна. Хөрөнгийн орлогын 74.3 хувийг хөрөнгө худалдсаны орлогоос, 25.7 хувийг өмч хувьчлалын орлогоос олжээ.

Зураг 9.Төсвийн зарлагын бүтэц, сая төгрөг



Нийслэлийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2010 онд 108663.3 сая төгрөгөөр төлөвлөгдсөн боловч зарлагын хэмжээ оны эцэст 103523.9 сая төгрөг болж 5139.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу хийгджээ. Орон нутгийн төсвийн нийт зарлагын 12.8 хувийг цалин хөлс болон шимтгэлийн зардал, 23.6 хувийг бараа үйлчилгээний зардал, 25.6 хувийг татаас, 1.5 хувийг урсгал шилжүүлэг, 1.4 хувийг хүнс барааны нөөц бүрдүүлэлтийн зардал, 35.1 хувийг дотоодын хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна.

Төсвийн зарлагын санхүүжилтын төлөвлөгөөний биелэлт 2009 онд 96.1 хувьтай байсан бол 2010 онд 95.3 хувь болж 0.8 пунктээр буурсан байна.

Хүснэгт 14. Нийслэлийн төсвийн зарлага, дүүргээр, сая төгрөг

Дүүрэг	Зарлагын дүн				Орлогын дүн	Орлого, зарлагын зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү		
Багахангай	611.9	617.1	100.8	-5.2	39.9	-577.2
Багануур	1284.9	1350.1	105.1	-65.2	790.1	-560
Баянгол	2597.4	2577.2	99.2	20.2	3508.7	931.5
Баянзүрх	3999.6	3933.8	98.4	65.8	4108.3	174.5
Налайх	1323.5	1402.3	106.0	-78.8	394.2	-1008.1
Сүхбаатар	4252	3796.1	89.3	455.9	4790.8	994.7
Сонгинохайрхан	2320.1	2148.9	92.6	171.2	1768.3	-380.6
Хан-Уул	3338.9	3266.3	97.8	72.6	7109.8	3843.5
Чингэлтэй	2872.8	2802.2	97.5	70.6	3056.5	254.3
Нийслэлийн шууд	86062.2	81629.9	94.8	4432.3	138707.8	57077.9
Нийт дүн	108663.3	103523.9	95.3	5139.4	164274.4	60750.5

Нэг хүнд ногдох төсвийн орлогын хэмжээ 2010 онд 144.8 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 18.0 хувиар, төсвийн зарлага 91.3 мянган төгрөгт хүрч 61.9 хувиар өссөн байна.

Нийслэлийн төсвийн орлого Монгол улсын нийт төсвийн орлогын 45.3 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд орон нутгийн төсвийн зарлагын 34.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 15. Орон нутгийн төсвийн орлого, зарлага , бүс, аймаг, нийслэлээр, сая төгрөг

Аймаг, нийслэл	Төсвийн орлого		Төсвийн зарлага	
	2009 он	2010 он	2009 он	2010 он
БҮГД	283717.1	362434.5	205399.6	298590.7
Баруун бүс	20486.3	25608.2	19566.2	24648.5
Баян-өлгий	3739.6	4332.3	3372.7	4310.9
Говь-Алтай	3878.4	5175.7	3843.2	4928.9
Завхан	4089.8	5067.0	4191.0	5649.8
Увс	4212.3	5295.9	4313.9	4520.0
Ховд	4566.2	5737.3	3845.4	5238.9
Хангайн бүс	55291.6	68974.9	51847.4	68473.7
Архангай	3788.5	5191.0	3791.8	5199.8
Баянхонгор	4228.6	5379.5	4202.2	5046.3
Булган	4562.2	5170.3	4521.4	4901.1
Орхон	32710.4	40711.4	30020.1	40443.7
Өвөрхангай	4822.8	5883.5	4655.0	6156.5
Хөвсгөл	5179.1	6639.2	4656.9	6726.3
Төвийн бүс	60942.5	85181.1	59259.6	83360.5
Говьсүмбэр	1603.9	2483.6	1541.9	2228.2
Дархан-уул	6023.9	7695.2	5852.7	6694.3
Дорноговь	7164.2	8767.9	7074.4	8288.0
Дундговь	3182.1	3987.5	3144.2	3496.0
Өмнөговь	24862.4	40912.9	24294.9	41605.8
Сэлэнгэ	11485.0	14413.7	10589.5	13683.7
Төв	6621.0	6920.3	6762.0	7364.5
Зүүн бүс	13615.7	18395.8	13399.0	18584.1
Дорнод	4609.6	5382.7	4565.8	5282.3
Сүхбаатар	4615.7	7445.4	4616.3	7557.4
Хэнтий	4390.4	5567.7	4216.9	5744.4
Улаанбаатар	133381.0	164274.5	61327.4	103523.9

НИЙСЛЭЛИЙН ӨМЧ


Нийслэл хотын өмч 2010 онд 82.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, бүртгэлийн дүнгээр 659.4 тэрбум төгрөг болжээ.

Нийт хөрөнгийн 16.4 хувийг эргэлтийн хөрөнгө, 83.6 хувийг эргэлтийн бус хөрөнгийн дүн эзэлж байна

2010 онд нийслэлийн Өмчийн харилцааны газар 8 барилга байгууламж объект, 1 нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын тодорхой хувийг дуудлага худалдаанд оруулан хувьчилж, нийслэлийн төсөвт 1343.2 сая төгрөгийн орлого оруулжээ.

Нийслэлийн өмчийг байршлаар авч үзвэл, нийт хөрөнгийн 21.4 хувь нь Баянзүрх, 20.5 хувь нь Чингэлтэй, 13.8 хувь нь Сүхбаатар, 13.8 хувь нь Баянгол, 12.6 хувь нь Сонгинохайрхан, 10.1 хувь нь Хан-Уул, үлдсэн 7.8 хувь нь Багануур, Багахангай, Налайх дүүрэгт тус тус байршиж байна.

Зураг 10. Нийслэлийн өмч, дүүргээр, тэрбум төгрөг



Хүснэгт 16. Нийслэлийн өмч, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Нийслэлийн өмч	318.6	391.2	372.1*	318.5*	576.5*	659.4*
үүнээс тухайн онд хувьчлагдсан /сая төгрөг/	1807.0	1395.0	2274.0	3216.8	375.1	1343.2

* - 2007 оноос эхлэн нийт хөрөнгийн дүнгээс хуримтлагдсан элэгдэл хасаж тооцох болсон


Хүснэгт 17. Нийслэлийн өмчийн бүтэц, тэрбум төгрөгөөр

Байгууллагын төрөл	2008 он		2009 он		2010 он	
	тоо	тэрбум төгрөг	тоо	тэрбум төгрөг	тоо	тэрбум төгрөг
Төсөвт байгууллага	409	152.5	424	374.7	438	411.2
Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар	50	148.3	25	131.1	28	125.2
Нийслэлийн өмчийн оролцоотой газар	8	13.6	9	20.1	8	66.4
Өрхийн эмнэлэг	124	4.1	123	5.4	123	9.2
Менежментийн гэрээтэй байгууллагууд	-	-	19	45.2	20	47.4
Дүн	591	318.5	600	576.5	617	659.4

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага 2010 онд давхардсан тоогоор 2902.9 мянган хүнд үйлчилж, нийгмийн даатгалын үйлчилгээний хүрээ өмнөх оныхоос 32.7 хувиар буюу 715.2 мянган хүнээр нэмэгдсэн байна.

Зураг 11. Нийгмийн даатгалын сангийн орлого, сая төгрөг



Зураг 12. Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төгрөг




Хүснэгт 18. Нийгмийн даатгалаар үйлчилсэн хүний тоо

		2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Бүгд		3735677	1853685	2098951	2187659	2902861
Үүнээс	НД-ын 5 төрлийн даатгалд заавал даатгуулагч	263379	290260	333069	332696	360688
	НД-д сайн дураар даатгуулагч	9108	13784	17931	20206	28089
	ЭМД-д заавал болон сайн дураар даатгуулагч	85820	117811	123271	134316	149021
	Тэтгэвэр авагч иргэд	104723	107896	111479	113358	116737
	Тэтгэмж, төлбөр авагч иргэд	54209	58110	64097	67141	72269
	ЭМД-ын шимтгэлийг төрөөс төлдөг иргэн	389053	409765	409179	424762	483262
	Эмчилгээ үйлчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон иргэд	2596143	540625	714062	744367	1232883
	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээлгэсэн иргэд	233242	315434	325863	350813	459912

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага 2010 оны нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 116.4 хувиар биелүүлж, даатгалын санд нийт 237.9 тэрбум төгрөг хуримтлуулав.

Нийгмийн даатгалын санд хуримтлуулсан нийт орлогын 63.1 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 20.8 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 4.5 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 7.2 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд, 4.4 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрсөн байна.

Зураг 13. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо



Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 53.3 тэрбум төгрөгөөр буюу 28.9 хувиар нэмэгдсэн байна. 2010 онд нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага 1421889 даатгуулагч, иргэдэд 227.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон нь өмнөх оныхоос 16.5 хувиар буюу 32.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын тэтгэврийн сангаас сард дунджаар 116.7 мянган хүнд тэтгэвэр олгосон бөгөөд олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 163.4 тэрбум төгрөгт хүрчээ. Нийслэлийн тэтгэвэр авагч нэг хүний сарын дундаж тэтгэврийн хэмжээ 119.7 мянган төгрөг байна. Түүнчлэн нийгмийн даатгалын сангаас нийт 72.3 мянган хүнд тэтгэмж, нөхөн төлбөр олгожээ.

Хүснэгт 19. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, дүүргээр, сая төгрөгөөр

	2004 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Багануур	1685.7	1893.0	2336.1	2998.7	3642.7	3926.1	4894.3
Багахангай	171.9	165.0	182.1	234.3	336.3	313.3	407.6
Баянгол	15853.8	18610.6	21636.9	28312.8	33920.2	36968.5	46528.4
Баянзүрх	7476.7	8701.8	11178.1	15838.4	20784.3	23811.6	29635.7
Налайх	729.4	810.8	1033.6	1371.1	1779.3	1955.0	2214.2
Сонгинохайрхан	4181.5	5137.1	5938.1	8214.0	10144.9	11748.2	14837.6
Сүхбаатар	12345.2	14420.2	18980.1	27683.8	36760.9	43926.7	59912.2
Хан-Уул	10950.8	11577.6	14589.5	18672.3	21673.0	24797.3	32717.7
Чингэлтэй	10621.7	13230.6	16546.7	22904.0	28011.5	34060.6	42546
Нийслэлийн НДГ	22.9	18.3	14.4	1595.3	2658.9	3039.7	4162.3
Нийслэлийн дүн	64039.6	74565.0	92435.6	127824.7	159712.0	184547.0	237856.0

Хүснэгт 20. Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төгрөгөөр

Сангийн төрөл	2004 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Тэтгэврийн даатгал	39675.2	46900.6	64224.3	97598.2	137771.6	142095.9	157077.5
Тэтгэмжийн даатгал	2163.9	2484.7	2882.8	4016.5	7129.1	11218.8	12838.3
Эрүүл мэндийн даатгал	9279.3	10362.6	12542.8	15535.6	29265.5	32518.6	45155.6
ҮОМШӨ-ний даатгал	1658.1	1946.4	2785.9	4463.7	6041.8	6191.1	6595.6
Ажилгүйдлийн даатгал	436.1	548.1	825.1	960.4	1573.4	2947.6	5486.4
Нийслэлийн дүн	53212.6	62242.4	83260.9	122574.4	181781.4	194972.0	227153.4

ХОТЖИЛТ БА ХҮНИЙ ХӨГЖИЛ

Монгол улсын хувьд зөвхөн Улаанбаатар хотод хүн ам олноороо төвлөрч, нягтрал бий болж байна. Хүн амын энэ төвлөрөлийг багасгахыг онцгой анхаарахаас илүүтэй үүнийг үр ашигтай ашиглах нь ойрын ирээдүйд нийслэл хотын хөгжилд хөшүүрэг болно. Ялангуяа амьдрах тав тухтай таатай орчныг бий болгохын тулд байгаль орчин ба хүн ам, эдийн засгийн нягтралыг бий болгох, үйлдвэрлэл, хүн амын хэрэглээнээс орчинд үзүүлэх дарамтыг бууруулах, орчинд ээлтэй технологи, бараа, үйлчилгээний зах зээлийн өсөлтийг дэмжих, орчинд ээлтэй, үр ашигтай хөрөнгө оруулалтыг ихэсгэх арга хэрэгслийг өргөн дэлгэр ашиглах хэрэгтэй.

Нийслэлд хотод манай улсын их дээд сургуулиудын 88.5 хувь нь байршиж, түүнд нийт оюутан сурагчдын 95.3 хувь нь суралцаж байна.

Монгол улсын барилга угсралт, их засварын ажлын 67 хувь, худалдааны үйлчилгээний борлуулалтын байгууллагуудын 51 хувь нь нийслэлд хийгдэж байна.

Улаанбаатар хот - Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын гол төв юм. Эрүүл мэнд, сургууль, аж үйлдвэр, санхүүгийн үйл ажиллагаа, өндөр орлоготой хүмүүсийн төвлөрлөөс харахад Монгол Улсын эдийн засагт Улаанбаатар хотын гүйцэтгэх үүрэг асар их. Улсын нийт хүн амын 41 гаруй хувь, аж ахуйн нэгж, байгууллагын 66 хувь зөвхөн Улаанбаатар хотод суурьшиж байгаагаас иргэдийн хадгаламж, банкны зээл, автомашин, их эмчийн дийлэнхи хувь нь бас ногдож байгааг зураг 14-өөс харж болно.


Хот суурин газарт хүн амын дийлэнх төвлөрч байгаа нь тухайн газар нутгийн хүн амын бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт, хэрэгцээг нэмэгдүүлж, тэр хэрээр эдийн засгийн үйл ажиллагааг өргөжүүлэх боломжийг бий болгож байна.

Хот өөрөө нийгэм, эдийн засаг, засаг захиргаа, соёлын байгууллагууд төвлөрсөн томоохон суурин газар гэдгээрээ хүн бүхэн өдөр тутам хийдэг эдийн засгийн, нийгмийн, улс төрийн эсвэл соёлын гэх мэт олон чиглэлээрх сонголтыг хийх өргөн боломжийг хүнд олгож байдаг.

Зураг 14. Төвлөрөл, хувиар



Зураг 15. Нэг хүнд ногдох ДНБ-ий индекс, бүс нутгаар




Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр Улаанбаатар хот улсын дунджаас өндөр байна. Монгол улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 онд 3.1 сая төгрөг болж, 2009 оноос 700 гаруй мянган төгрөгөөр нэмэгджээ.

Улаанбаатар хотын барилгын үйлдвэрлэл болон үйлчилгээний салбар нь хөдөө орон нутгаас шилжин ирэгчдийг шингээх гол зах зээл болж байна. Судалгааны дүнгээс үзэхэд¹, шилжин ирэгчдийн дийлэнх нь хувийн аж ахуйн нэгж байгууллагад ажилладаг, хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна.

Нийслэл хотод манай улсын эдийн засгийн идэвхитэй хүн амын 34.4 хувь нь төвлөрчээ.

Зураг 16. Эдийн засгийн идэвхи, бүс нутгаар, 2010 он




Улаанбаатар хотод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын тоо 1997 онд 2697 байсан бол 2008 онд 22066 болж 8.2 дахин, 2010 онд 29486 болж, даруй 11 дахин тус тус ссөн байна.

¹ ХАССТ, НХХЯ, НҮБХАС, 2009. “Монгол Улсын Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар” судалгаа, Улаанбаатар хот

Нийслэл хотын эдийн засаг нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, засварын үйлдвэрлэл хувийн хэрэглэгчдийн тусламж дэмжлэгтэйгээр эрчимтэй өсч байна. Бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилгын үйлдвэрлэл нь Улаанбаатар хотын эдийн засгийг идэвхжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулж байна.

Зураг 17. Ажилгүйдлийн түвшин, бүс нутгаар



Хот суурин газар шилжин ирснээр шилжигчид ажил эрхлэх боломж нэмэгдэж, амьжиргааны эх үүсвэртэй болж байна.

Улаанбаатар хотод сүүлийн жилүүдэд шинээр бий болж байгаа ажлын байрны тоо тогтмол өсч байгаа ч ажилгүй иргэдийн тоо төдийлэн буурахгүй байна. Үүний гол шалтгаан нь тухайн жилд шинээр бий болж буй ажлын байртай тэнцэхүйц хэмжээний хүн нийслэлд шилжин ирж байгаатай холбоотой. Нийслэлд ажил эрхлэх боломж байгаа ч шилжин ирэгчид нь мэргэжил, ур чадварын хувьд гологдож байна.

Хотжилтыг нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлсийг хүмүүст ээлтэй болгоход ашиглаж болох ч өнөөдрийг хүртэл хотжилт хүн амын ядуурлыг шууд бууруулж, тэгш бус байдлыг багасгахад төдийлэн нөлөө үзүүлж чаддаггүй нь судалгаа шинжилгээний дүнгээр тодорхой байна.

Зураг 18. Хотжилт ба тэгш бус байдал, сонгосон орноор




Эх сурвалж: “Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд 2009” Дэлхийн банк

Зураг 18-аас харахад зарим улс орны хувьд хотжилтын түвшин өндөр ч тэгш бус байдал нь хотжилтын түвшин бага улс оронтой харьцуулахад өндөр байна.

Хотын эдийн засаг буюу хотын хөдөлмөрийн зах зээл хот сууринд амьдран суугчдыг бүгдийг шингээж чаддаггүй тул шилжин ирэгсэд болон ядуучууд нь ажилгүй, орлогогүй хэвээр үлдэх магадлал өндөр байдаг.

Хотын ядуурал нь ажилгүйдлээс бус бүрэн бус ажил эрхлэлтээс илүү шалтгаалсан байдаг. Улаанбаатар хотын ядуурал нь жил бүр нэмэгдэж байгааг зураг 19-өөс харж болно. 2010 оны судалгаагаар нийслэл хотын хүн амын 29.8 хувь нь ядуу амьдарч байна.

Зураг 19. Ядуурлын хамралт, бүс нутгаар




Манай улсын хувьд бүс нутгийн буюу бүсчилсэн хөгжлөөр дамжуулан хүн амын шилжилтийн эрч хүчийг сааруулах, хэт төвлөрлийг багасгах, өндөр хөгжилтэй улс орнуудад хэрэгжүүлж байсан бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээ тодорхой түвшинд хэдийнээ бүрэлдсэн.

“Улаанбаатар бүсийн хөгжлийн хөтөлбөр 2005-2015”, “2020 он хүртэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө” гэсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд Улаанбаатар хотоос зарим үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлж нийслэл хот орчмын дагуул хот, тосгодыг хөгжүүлэх, тэнд шинээр үйлдвэрүүдийг барьж байгуулах замаар Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн, хүн амын хэт төвлөрлийг сааруулах бодлогыг тусгасан. Дэлхийн хөгжилтэй улс орнуудын туршлагаас² үзэхэд, бүс нутга өөрийн гэсэн өрсөлдөх чадвартай байх нь тэдний ялгарах шинж чанар болж, улмаар эдийн засгийн хувьд бие биенээсээ харилцан хамааралтай бүтэц бүрдэх үндэс болдог. Ийм бүтцийг бүрдүүлэхдээ шилжин суурьшсан хүн амд хэрэгцээт зүйлсийг шууд тараан өгөх бус тэдний бизнесийн үйл ажиллагааг явуулах нөхцлийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын болон амьдрах таатай орчин бүрдүүлэх зохицуулалтын арга хэмжээг илүү ашигласан байна.

² ХАССТ, НХХЯ, НҮБХАС, 2009. “Монгол Улсын Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар” судалгаа, Улаанбаатар хот

Монгол улсын Мянганы Хөгжлийн үндэсний хэмжээнд дэвшүүлсэн нийт 22 зорилтын биелэлт хангалттай байгаа. Улаанбаатар хотын үнэлгээнд³ 42 шалгуур үзүүлэлт тооцогдсоны 2.4 хувь “эрт хүрсэн”, 52.4 хувь “зорилтыг хангах боломжтой”, 19.0 хувь “удаан”, 26.2 хувь “ухарсан” үзүүлэлтүүд болж байна.

Зураг 20. Хүний хөгжлийн индекс, бүс нутгаар



Мянганы хөгжлийн “Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах” гэсэн 4 дүгээр зорилтын хүрээнд төрийн зүгээс шилжин суурьшигчдын бүртгэлийг сайжруулах, тэдний олноор бөөгнөрдөг хотын захын хорооллуудад дэд бүтэц, нийгмийн үйлчилгээг ойртуулах арга хэмжээг авсаар байна. Ялангуяа Улаанбаатар хотын нийт хүн амыг хаягжуулах ажилд⁴ 2.9 жил шаардлагатай бөгөөд хаягийн бүртгэлгүй оршин суугч хүн амыг 0 болгох “зорилт хангагдах боломжтой” байна.

Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилтуудын 14 дүгээр зорилтод “2015 он гэхэд баталгаат ундны ус хэрэглэх боломжгүй хүн амын эзлэх хувийг 2 дахин бууруулах” гэж заасан ч уур амьсгалын өөрчлөлт, ахуйн зохисгүй үйл ажиллагаанаас газрын доорх ба дээрх усны нөөц хомсдож, чанар нь доройтож, бохирдож байна. Энэхүү үзүүлэлтийн биелэлт “удаашралтай” байна. Учир нь Туул голын ус татарч, голын ай сав бохирдон, ой мод, хөрс ургамлын бүрхэвч доройтсоноос газрын доорх усны тэжээл багассаар байгаа нь хүн амын төвлөрөл ихтэй нийслэлийн хувьд ундны усны нөөц хүрэлцээг нарийвчлан тооцохын зэрэгцээ МХЗ-н дээр зорилтод хүрэхэд бидэнд багагүй бэрхшээл байгааг харуулж байна.

МУМХЗ-ын 15 дугаар зорилт “2015 он гэхэд орон байрны нөхцөл муу хүмүүсийн аж байдлыг мэдэгдэхүйц сайжруулах”-ын хүрээнд Улаанбаатарын хувьд үзүүлэлтийн биелэлт “удаашралтай” байна. Хүн амын нэлээд хувь нь хот суурин газар амьдарч байгаа ч орон сууцны нөхцөл ялгаатай, ихэнх нь инженерийн болон нийгмийн дэд бүтэц, хангамж, түүний найдвартай үйлчилгээгээр хангагдаж чадаагүй л байна.

Улаанбаатар хотын хүн амын огцом өсөлт, гэр хорооллын тэлэлтийг дагаад орчны бохирдлын асуудал тэргүүн зэрэгт шийдвэрлэх асуудлын нэг болж байна. Хүн амын хэт төвлөрөл, нийгмийн болон нийтийн үйлчилгээний хэт ачааллаас үүдэлтэй хөрсөн

³ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, НҮБХХ, 2009. “Улаанбаатар хотын Мянганы хөгжлийн зорилтууд”, Анхны илтгэл, Улаанбаатар хот

⁴ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, НҮБХХ, 2009. “Улаанбаатар хотын Мянганы хөгжлийн зорилтууд”, Анхны илтгэл, Улаанбаатар хот.

бүрхэвч, усан орчин, агаарын чанарын бохирдол, хог хаягдал зэрэг нь бидний амьдралын тав тухтай таатай орчинд сөргөөр нөлөөлж улмаар хүний хөгжлийг хангах боломжийг хязгаарлагч хүчин зүйл болжээ.

Хүснэгт 21. Хотын хүн амын өсөлтийн үр нөлөө

Явагдаж буй өөрчлөлт	Өөрчлөлтийн дүнд гарах нөлөөлөл	Нөлөөллийн гол шалтгаан
Хотын захын хаяа тэлэлт <ul style="list-style-type: none"> • Гэр хороолол • Орон гэргүйчүүд • Хуулиар зөвшөөрөгдөөгүй суурьшлын бус газар 	<ul style="list-style-type: none"> • Хөрсний бохирдол • Амь нас, эд хөрөнгөө алдах эрсдэл 	<ul style="list-style-type: none"> • Хот байгуулалтын алдаатай бодлого • Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа сул • Бага орлоготой өрхүүд орон сууцаар хангагдах боломж муу
Тээвэр, түлш шатахуун, дулаан хангамжийн хэрэглээний өсөлт	<ul style="list-style-type: none"> • Агаарын бохирдол 	<ul style="list-style-type: none"> • Автомашины тоо нэмэгдсэн • Гэр хороололд оршин суугчид хямд түлш хэрэглэдэг • Дулаан хангамжийн нийлүүлэлтийг улсаас хариуцан, зохицуулдаг
Хатуу хог хаягдал нэмэгдэлт	<ul style="list-style-type: none"> • Хөрсөн бүрхэвч болон агаарын бохирдол 	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдал зайлуулалт, түүний менежмент муу • Зориулалтын хог хаягдал зайлуулах байгууламж байхгүй
Усны хэрэглээний өсөлт	<ul style="list-style-type: none"> • Гүний усны бохирдол 	<ul style="list-style-type: none"> • Нийтийн нөөцөөс ашиглалтын зохицуулалт сул
Үйлчилгээний эрэлт хэрэгцээний өсөлт <ul style="list-style-type: none"> • ариун цэврийн байгууламж • хог хаягдал зайлуулалт 	<ul style="list-style-type: none"> • Үйлчилгээний ачаалал ихсэлт • Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, байгууламжийн хүчин чадал сулралт 	<ul style="list-style-type: none"> • Нийлүүлэлтийг улсаас хариуцдаг • Үнийг зохицуулахад хүнд • Татаас ихтэй

МУМХЗ-ын 12 дугаар зорилтод “Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх” гэж заасан нь энэхүү асуудалд бодлогын түвшинд ихээхэн анхаарч, энэ талаарх эдийн засаг, байгаль орчны хамтарсан олон талт арга хэмжээг зохион байгуулж байна. Улаанбаатар хотын агаар дах азотын давхар ислийн болон хүхэрлэг хийн өвлийн хоногийн дундаж агууламж хэдийгээр улсын хэмжээнд дэвшүүлсэн “зорилтыг хангах боломжтой” гэж үнэлэгдэж байгаа ч тэдгээрийн агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс давах тохиолдол нэмэгдсээр байна.

Хот суурингийн хүн амыг шаардлагатай цэвэр ус, дулаан хангамж, эрчим хүчээр хангаж буй өнөөгийн үйл ажиллагаа нь бохирдол, хог хаягдал үүсэх үндсэн нөхцөл, шалтгаан болж байна. Хот төлөвлөлтийн алдаатай бодлого, ялангуяа газар зохион байгуулалт муу, нийгмийн дэд бүтцийн хангамж төрийн мэдэлд байдаг, хот суурингийн болон байгаль орчны доройтлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх хууль эрх зүйн зохицуулалтын орчин бүрдээгүй зэрэг олон шалтгааны улмаас хотжилт эдийн засгийн хөгжлийг дэмжигч бус харин хойш чангаагч хүчин зүйл болсон байна.


ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний үнийн индекс 2008 онд өмнөх оноос 8.1 нэгжээр өсч 23.2 хувь, 2009 онд 21.3 нэгжээр буурч 1.9 хувь, 2010 онд 12.4 нэгжээр нэмэгдэж 14.3 хувьд хүрсэн байна.

2010 оны жилийн эцэст өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ бүх аймагт 6.2-18.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2010 оны 12-р сард хэрэглээний сагсанд авсан 287 нэр төрлийн хэрэглээний бараа, үйлчилгээний 25.0 хувийнх нь үнэ өсч, 4.5 хувийнх нь буурч, 70.5 хувь нь тогтвортой байлаа.

Зураг 21. Хэрэглээний үнийн индекс, аймаг, хотоор, /өмнөх онтой харьцуулснаар/



Хүснэгт 22. Хэрэглээний үнийн индекс,


	$\frac{2007\text{-XII}}{2006\text{-XII}}$	$\frac{2008\text{-XII}}{2007\text{-XII}}$	$\frac{2009\text{-XII}}{2008\text{-XII}}$	$\frac{2010\text{-XII}}{2009\text{-XII}}$
ЕРӨНХИЙ ИНДЕКС	115.1	123.2	101.9	114.3
ХҮНСНИЙ БАРАА, УНДАА, УС	124.6	124.5	99.5	120.6
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ	102.7	108.9	122.1	108.3
ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	103.0	126.1	103.7	112.1
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ТҮЛШ	111.3	117.4	96.1	112.5
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	113.9	114.6	106.5	104.5
ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	114.2	127.4	114.2	103.6
ТЭЭВЭР	110.6	133.8	99.2	101.8
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	89.3	96.1	107.0	116.9
АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	104.2	108.8	101.9	101.5
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	120.2	137.6	109.0	120.4
ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	114.0	134.4	112.0	114.9
БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	103.8	115.6	115.9	103.1

Хүснэгт 23. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс

Бүлэг	2010-XII 2009-XII	2010-XII 2010.XI
ЕРӨНХИЙ ИНДЕКС	114.3	102.4
1.ХҮНСНИЙ БАРАА, УНДАА, УС	120.6	105.2
01.1 ХҮНСНИЙ БАРАА	121.3	105.3
01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	100.5	100.1
2.СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ	108.3	101.9
02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА	103.5	100.2
02.2 ТАМХИ	112.8	103.4
3.ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	112.1	100.6
03.1 ХУВЦАС, БӨС БАРАА	109.9	100.4
03.2 ГУТАЛ	116.9	101.0
4.ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ТҮЛШ	112.5	100.1
04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС	97.9	99.0
04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	105.3	101.9
04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	124.1	100.0
04.4 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	108.0	100.0
5.ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	104.5	99.7
05.1 ТАВИЛГА, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН БУСАД ДЭВСГЭР	101.0	100.0
05.2 ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	111.8	100.7
05.3 ЦАХИЛГААН БАРАА	102.7	98.2
05.4 ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	115.0	100.8
05.5 ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ	111.6	102.2
05.6 ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА	104.1	100.0
6.ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	103.6	100.1
06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ	100.3	100.2
06.2 АМБУЛАТОРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	113.6	100.0
06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ЭМЧЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ	109.4	100.0
7.ТЭЭВЭР	101.8	100.0
07.1 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	109.4	100.0
07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ	100.8	100.0
07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	101.7	100.0
8.ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	116.9	100.0
08.1 ХОЛБОО, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	116.9	100.0
9.АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	101.5	100.3
09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, БУСАД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	97.0	99.5
09.2 ЧӨЛӨӨТ ЦАГТ ЗОРИУЛСАН БУСАД ХЭРЭГСЭЛ	109.7	104.4
09.3 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.6	100.0
09.4 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	102.7	100.0
10.БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	120.4	100.0
10.1 БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	120.4	100.0
11.ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	114.9	100.4
11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	114.8	100.5
11.2 ЗОЧИД БУУДАЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	115.9	100.0
12.БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	103.1	100.1
12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	103.4	100.1
12.2 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	102.5	100.0
12.3 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0

Нийслэл хотод хэрэглээний үнийн ерөнхий индекс 2010 онд 14.3 хувиар өссөн байна. Тухайлбал, хүнсний бараа, ундаа ус бүлгийн дүнгээр 20.6 хувь, согтууруулах ундаа, тамхи 8.3 хувь, хувцас, бөс бараа, гутал 12.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлш 12.5 хувь, гэр ахуйн бараа 4.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 3.6 хувь, тээвэр 1.8 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 16.9 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын барааны үйлчилгээ 1.5 хувь, боловсролын үйлчилгээ 20.4 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 14.9 хувь, бусад бараа, үйлчилгээ бүлгийн дүнгээр 3.1 хувиар тус тус өсчээ.

Зураг 22. Хэрэглээний үнийн өсөлт, 2008-2010 оны сар бүрээр, (өмнөх сар 100%)




Хүснэгт 24. 2010 оны 12-р сарын Хэрэглээний үнийн индекс,бүлгээр, 2005-XII=100%

Барааны бүлгээр	УБ	УЛС
ХҮНСНИЙ БАРАА, УНДАА, УС	190.1	197.9
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ	151.9	164.2
ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	160.4	161.4
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ТҮЛШ	149.0	171.8
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	155.0	162.2
ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	195.4	186.9
ТЭЭВЭР	164.4	168.1
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	86.0	94.4
АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	125.8	127.7
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	239.3	238.1
ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	209.1	201.6
БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	160.2	160.6
ЕРӨНХИЙ ИНДЕКС	171.5	179.7

Улаанбаатар хотын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн 2010 оны 1-12 сар хүртэлх индексийг 2005 оны жилийн эцэстэй харьцуулахад 54.0-74.3 хувь хүртэл өссөн үзүүлэлт ажиглагдаж байна.

Зураг 23. Хэрэглээний үнийн индексийн харьцуулалт




Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2010 онд 14.3 хувийн өсөлттэй байснаас 4.0 нэгж нь хүнсний бараа, ундаа ус, 1.0 нэгж нь согтууруулах ундаа, тамхи, 2.5 нэгж нь орон сууц, ус, цахилгаан түлш, 2.8 нэгж нь хувцас, бөс бараа, гутал, 4.0 нэгж нь боловсролын үйлчилгээнийх зэрэг бүлгийн үнийн өсөлтөөс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 25. УБ хотын зарим бараа, үйлчилгээний жилийн дундаж үнэ

Бараа, үйлчилгээ	2007 он	2008 он	2009 он	2010 он
Гурил, 1-р зэрэг, кг	493	783	726	637
"Атар" талх	360	592	612	631
Цагаан будаа, кг	722	1133	1373	1639
Хонины мах, кг	2642	3371	2860	3790
Үхрийн мах, кг	2851	3674	3309	4291
Сүү, л	568	843	974	1087
Хуурай сүү, кг	3597	5670	6465	6171
Элсэн чихэр, кг	870	918	1289	1696
Ногоон цай, 2кг	2732	3200	4164	4603
Алим, кг	1212	1565	1713	1900
Төмс, кг	558	890	954	971
Байцаа, кг	550	771	847	1045
Лууван, кг	592	950	1039	961
Манжин, кг	542	917	1091	922
Сонгино, кг	580	678	782	1037
Ургамлын тос, л	1848	2853	3009	2781
Өндөг, ш	146	203	208	215
Архи, 0.5л	3064	3584	4324	4409

2008 онд мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оноос 10.6 хувиар өссөн бол харин 2009 онд өмнөх оноос 7.7 хувиар буурсан байна. 2010 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонь, үхэр, адууны махны үнэ 14.7–57.5 хүртэл хувиар нэмэгджээ. 2010 оны 12-р сард нийслэлийн хүнсний захуудаар худалдаж буй хонины ястай мах дунджаар 3686 төгрөг, үхрийн ястай мах дунджаар 4047 төгрөгийн үнэтэй байна.

Зураг 24. Хонь, үхрийн 1 кг махны дундаж үнэ, төгрөг




Хүснэгт 26. Нэг кг махны дундаж үнэ, 2004-2010 оны сараар, (төгрөгөөр)

сар	Хонины мах						
	2004 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
1	1333	1722	2084	2108	2772	2724	2688
2	1594	1888	2260	2364	3036	2722	3103
3	1522	1900	2157	2491	3211	2980	3605
4	1725	2183	2394	2656	3710	3385	4165
5	1781	2405	2411	2825	3929	3593	5120
6	1875	2601	2622	3138	4086	3468	5225
7	1822	2553	2591	3090	4156	3096	4195
8	1647	2339	2450	2970	3719	2781	3861
9	1567	2146	2248	2774	3424	2547	3490
10	1403	1915	2065	2439	2993	2309	3146
11	1439	1870	1946	2350	2685	2350	3190
12	1544	2003	2027	2464	2678	2356	3686
	Үхрийн мах						
1	1463	1888	2326	2331	3035	3011	3169
2	1769	2193	2368	2541	3264	3076	3868
3	1571	2243	2354	2666	3411	3555	4180
4	1764	2435	2600	2846	3947	3642	4807
5	1843	2635	2651	2905	4307	3855	5570
6	1933	2780	2789	3272	4544	3932	5789
7	2013	2656	2767	3146	4428	3613	4808
8	1713	2479	2589	3136	4020	3334	4254
9	1717	2392	2544	3043	3760	3028	3934
10	1600	2186	2387	2826	3264	2880	3599
11	1650	2134	2293	2703	3061	2897	3539
12	1775	2265	2294	2782	2992	2828	4047

2010 оны жилийн эцсийн байдлаар мах, махан бүтээгдэхүүний бүлгийн индекс ноднингийн мөн үетэй харьцуулахад 43.6 хувь, өмнөх сартай харьцуулахад 11.3 хувиар өссөн байлаа.

Зураг 25. Нэг кг төмсний үнэ, төгрөг




Зураг 26. Нэг кг луувангийн үнэ, төгрөг



2010 оны 12-р сард төмс, хүнсний ногооны бүлгийн үнийн индекс 2009 оны мөн үетэй харьцуулахад 18.2 хувиар, 2010 оны 11-р сараас 1.1 хувиар өссөн байна. 2010 онд “Монгол” гэсэн тодотголтой төмс, луувангийн дундаж үнэ 2007 оноос 369-413 төгрөгөөр, 2008 оноос 11-81 төгрөгөөр, 2009 онд төмс 17 төгрөгөөр өсч, харин лууван 78 төгрөгөөр буурсан эерэг үзүүлэлттэй байв.

Зураг 27. Хүнсний ногооны нэг кг-ын үнэ, төгрөг




Талх, гурил, будааны бүлгийн үнийн индекс 2008 оны жилийн эцсийг 2007 онтой харьцуулахад 35.4 хувь, 2009 оныг 2008 онтой харьцуулахад 0.5 хувь, 2010 оныг 2009 онтой харьцуулахад 10.1 хувиар тус тус өсчээ.

2010 оны эхний хагас жилийн байдлаар “Алтан тариа” дээд гурилын үнэ дунджаар 692 төгрөг байснаа сүүлийн хагас жилд 814 төгрөг болж дунджаар 17.6 хувиар нэмэгдсэн байна. I болон II зэргийн гурил эхний хагас жилд 476-594 төгрөг байснаа сүүлийн саруудад харьцангуй өсч 496-679 төгрөг болсон байв. Харин импортоор орж ирдэг орос болон хятад гурилын үнэ 2008 онд 749-866 төгрөг, 2009 онд 832-844 төгрөг байсан бол 2010 онд дунджаар 753-824 төгрөг болсон байна.

Зураг 28.Нэг кг дээд гурилын үнэ, төг




Зураг 29.Нэг кг 1,2-р зэргийн гурилын үнэ, төг




2010 онд шатахуун импортлогч томоохон компаниуд Аи-80, Аи-92, дизель түлшний үнийг 2 удаа нэмж, 4 удаа бууруулсан байна. Ингэхдээ автобензины үнэ 10-45 төгрөгөөр хэлбэлзэж, дизель түлшний хувьд 20-76 төгрөгөөр буурч, 35-61 төгрөгөөр өссөн байна.

Зураг 30. Аи-76,80 автобензины үнэ, төгрөг




Зураг 31.Аи-92,93 автобензины үнэ, төгрөг




АИ-76, 80 бензиний үнэ Төв аймагт хамгийн хямд буюу 1183 төгрөг байсан бол Дорноговь аймагт хамгийн үнэтэй буюу 1396 төгрөгөөр худалдаалагдаж, харин нийслэл хотод 1176 төгрөг байжээ.

2010 оны 6-р сард АИ-80 бензин 1220 төгрөг, АИ-92 бензин 1410 төгрөг, дизелийн түлшний үнэ 1376 төгрөг байсан нь энэ оны хамгийн өндөр үнэ байв. Энэ нь 2009 оны мөн үетэй харьцуулбал 36.2-54.9 хүртэл хувиар өсчээ.


Зураг 32. Дизель түлшний үнэ, төгрөг, 2008-2010 оны сараар



Зураг 33. Түлшний модны үнэ, төгрөг




Зураг 34. Нүүрсний үнэ, төгрөг



АЖ ҮЙЛДВЭР


Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2010 онд оны үнээр 1914.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2187.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2009 онтой харьцуулбал үйлдвэрлэлт 47.4 хувиар, борлуулалт нь 57.9 хувиар тус тус өссөн байна.

Зураг 35. Үйлдвэрлэлт, 2007-2010 он тэрбум төг



Өнгөрсөн оноос нүүрс олборлолт, төмрийн хүдэр болон бусад ашигт малтмал олборлолтын үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт, сүү, сүүн бүтээгдэхүүн, үр тарианы гурил, ундаа үйлдвэрлэл, мөн химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тамхи, цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, мод модон эдлэл үйлдвэрлэл, төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл 8.0-94.7 хувиар өссөн нь нийт үйлдвэрлэлтийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Зураг 36. Борлуулалт, 2007-2010 он тэрбум төг




Нийслэлийн аж үйлдвэрийн нийт борлуулалтын 950.2 тэрбум төгрөгийг дотоодод, 1237.1 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Манай улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтын 53.0 хувийг нийслэлийн аж үйлдвэрийн салбарын борлуулалт эзэлж байна. 2007-2010 оны сар бүрийн үйлдвэрлэлт, борлуулалтыг графикаас харахад нийслэлийн аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 27. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, борлуулалт, оны үнээр

	Нийт үйлдвэрлэлт, сая төгрөг	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, сая төгрөг	Үүнээс:		Ажиллагсдын тоо
			Дотоод борлуулалт	Гадаад борлуулалт	
2006 он	695925.0	697262.1	339107.3	358154.8	24492
2007 он	960395.7	960411.0	559966.4	400444.6	26085
2008 он	1092645.8	1127994.7	697496.7	430498.0	26069
2009 он	1298692.2	1384885.5	816248.6	568636.9	25296
2010 он	1914524.5	2187321.4	950249.9	1237071.6	26311

Зураг 37. Аж үйлдвэрийн салбарын бүтэц, оны үнээр, хувиар



2010 оны аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтэд цахилгаан, дулаан эрчим хүч, усан хангамжийн эзлэх хувь өмнөх оноос 1.3 пункт, боловсруулах аж үйлдвэрийн салбарын хувь 9.5 пунктээр буурч, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн эзлэх хувь 10.8 пунктээр өссөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэр Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын 54.5 хувийг уул, уурхайн салбарт үйлдвэрлэж байна. Уул уурхайн олборлох салбарын гол нэрийн бүтээгдэхүүний нэг болох нүүрс 2010 онд 12909.7 мянган тонныг олборлосон нь өмнөх оны мөн үеэс 99.7 хувиар өссөн байна.

2010 онд улсын хэмжээнд 100 гаруй аж ахуйн нэгж байгууллага нийт 6037.1 кг алт олборлосны 80.0 хувь буюу 4830.9 кг алтыг нийслэлд бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагууд олборлосон байна. Олборлосон алтны хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 35.1 хувиар буурсан байна.

Боловсруулах салбар Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлтэд боловсруулах салбарын бүтээгдэхүүн оны үнээр 2005 онд 36.5 хувь, 2006 онд 34.7 хувь, 2007 онд 39.3 хувь, 2008 онд 43.7, 2009 онд 45.0 хувь, 2010 онд 35.5 хувийг эзэлж байгаа нь 2009 оныхоос 9.5 пунктээр буурчээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт 2009 оныхоос 20.4 хувиар өсөхөд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тамхи үйлдвэрлэл, цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, мод, модон эдлэл үйлдвэрлэл, хэвлэх болон нийтлэх үйл ажиллагаа, төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл, мебель тавилга үйлдвэрлэл зэрэг салбарын үйлдвэрлэлийн өсөлт нөлөөлсөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн улсын дүнд нийслэлийн боловсруулах салбарын үйлдвэрлэлт 60.2 хувийг эзэлж байна.

Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж

2010 онд оны үнээр 190.1 тэрбум төгрөгийн цахилгаан, дулаан, ус үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 15.2 хувиар өслөө. 2010 онд улсын хэмжээнд 4312.8 сая.квт.цаг цахилгаан, 8.4 сая гксал дулаан, 61.7 сая метр куб ус түгээсэн бол үүнээс нийслэлийн хэмжээнд 3173.9 сая квт.цаг цахилгаан, 5.1 сая гкал дулаан, 43.2 сая метр куб ус түгээсэн байна.

Хүснэгт 28. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт,
салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Нийт бүтээгдэхүүн			
	2007 он	2008 он	2009 он	2010 он
Уул уурхай олборлох үйлдвэр	466792.0	469320.9	537584.7	1043286.7
Нүүрс олборлолт	32813.8	43144.2	105112.2	218090.0
Газрын тос, шатдаг хий олборлолт				219973.0
Төмрийн хүдэр олборлолт	388663.9	384697.4	378413.4	538804.8
Бусад ашигт малтмал олборлолт	45314.3	41479.3	54059.1	66418.9
Боловсруулах үйлдвэр	375201.1	477678.3	595235.3	680369.1
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	126344.8	219041.5	298266.6	398756.6
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	8749.4	24665.6	33339.7	31240.0
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5722.1	14281.8	20087.3	29026.7
Үр тарианы гурил, малын тэжээл	32183.0	50708.7	67116.0	77514.8
Хүнсний бусад бүтээгдэхүүн	28038.2	43305.4	46126.0	45031.5
Ундаа үйлдвэрлэл	51652.1	86080.0	131597.6	215943.6
Тамхи үйлдвэрлэл	23433.1	24226.4	33823.8	36915.4
Нэхмэлийн үйлдвэрлэлт	140619.1	139041.1	155662.8	135612.9
Хувцас үйлдвэрлэл	25203.0	11076.7	34411.1	2718.2
Арьс шир боловсруулах үйлдвэр	7025.5	2002.3	2060.9	360.7
Мод модон эдлэл үйлдвэрлэл	5548.7	4326.4	3772.5	6605.5
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2333.5	4394.8	6115.4	8829.4
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	10031.2	15071.8	13243.8	15820.6
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш	30.2	69.2	63.5	907.4
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7153.6	12652.1	13801.0	26868.3
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	699.2	291.0	419.7	416.7
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	19367.8	29814.8	20164.9	23752.8
Төмрийн үйлдвэрлэл	676.4	2183.9	285.2	1580.7
Машин, төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	891.9	3386.2	2596.2	1257.1
Машин тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.0	1280.6	3649.9	11077.0
Бичиг хэрэг, тооцоолох техник үйлдвэрлэл	1310.9	3204.2	154.9	170.0
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	926.6	1469.1	473.4	223.8
Эмнэлгийн багаж, хэмжүүр үйлдвэрлэл	993.9	839.6	781.3	367.6
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	1797.2	2090.0	2382.9	2369.0
Мебель болон бусад боловсруулах үйлдвэр	814.5	1216.6	3105.5	5759.4
Цахилгаан, дулаан, усан хангамж	118402.6	145646.6	165872.2	190868.7
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	102509.2	127317.8	146267.9	168994.8
Ус ариутгал, усан хангамж	15893.4	18328.8	19604.3	21873.9
ДҮН	960395.7	1092645.8	1298692.2	1914524.5

Хүснэгт 29. Аж үйлдвэрийн нийт борлуулалт, салбараар,
өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2007 он	2008 он	2009 он	2010 он
Уул уурхай олборлох үйлдвэр	458379.9	477741.8	619112.2	1275124.0
Нүүрс олборлолт	33188.3	42876.6	150672.2	436436.7
Газрын тос, шатдаг хий олборлолт	0.0	0.0	0.0	209244.7
Төмрийн хүдэр олборлолт	386890.5	386919.6	427652.5	566966.0
Бусад ашигт малтмал олборлолт	38301.1	47945.6	40787.5	62476.6
Боловсруулах үйлдвэр	383962.2	505165.4	600817.1	722140.1
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	141210.6	244834.9	341516.9	447464.6
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	10079.3	20498.1	55028.4	40185.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6021.2	14111.3	20568.9	29688.5
Үр тарианы гурил, малын тэжээл	28721.7	44820.4	69779.4	77128.5
Хүнсний бусад бүтээгдэхүүн	28097.0	43555.9	45793.6	45302.3
Ундаа үйлдвэрлэл	68291.4	121849.2	150346.6	255159.8
Тамхи үйлдвэрлэл	23433.1	24226.4	30897.0	39043.6
Нэхмэлийн үйлдвэрлэлт	137164.6	139061.2	151630.4	127877.0
Хувцас үйлдвэрлэл	25353.2	12185.1	3365.4	2390.1
Арьс шир боловсруулах үйлдвэр	7172.4	1439.1	2587.5	332.5
Мод модон эдлэл үйлдвэрлэл	3715.1	3800.7	3777.0	6336.2
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2803.9	5286.9	8503.1	10380.6
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	10273.8	15303.5	13246.4	15786.4
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш	30.2	69.2	64.2	886.6
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7632.5	14013.4	14289.3	26679.1
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	880.9	186.8	325.9	528.3
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	17332.3	29469.5	19539.2	23727.7
Төмрийн үйлдвэрлэл	676.4	2183.9	285.2	1580.7
Машин, төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	535.5	2778.5	2727.7	1513.2
Машин тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.0	1280.6	1123.4	9970.1
Бичиг хэрэг, тооцоолох техник үйлдвэрлэл	1173.4	3204.2	154.9	169.9
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	921.5	1469.9	469.6	713.9
Эмнэлгийн багаж, хэмжүүр үйлдвэрлэл	959.4	1069.4	829.0	551.0
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	1798.9	2239.7	2341.5	2387.5
Мебель болон бусад боловсруулах үйлдвэр	894.5	1062.5	3143.5	3821.1
Цахилгаан, дулаан, усан хангамж	118068.9	145087.5	164956.2	190057.3
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	102175.5	126758.6	145351.9	168183.4
Ус ариутгал, усан хангамж	15893.4	18328.9	19604.3	21873.9
ДҮН	960411.0	1127994.7	1384885.5	2187321.4

Хүснэгт 30. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүн

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Цахилгаан эрчим хүч	сая.квт.цаг	2414.1	2518.9	2678.3	2924.5	2952.1	3173.9
Дулааны эрчим хүч	мян.Гкал	4716.8	4654.8	4771.8	5024.1	5121.8	5123.8
Түгээсэн цэвэр ус	мян.м ³	40606.0	42178.8	44536.7	45495.9	43777.5	43148.5
Нүүрс	мян.тн	2893.6	3263.3	3111.0	4112.4	6465.3	12909.7
Алт	кг	10780.4	12354.1	14890.7	11441.4	7444.7	4830.9
Хайлуур жоншны баяжмал	мян.тн	133.3	137.6	131.8	142.9	115.3	140.7
Улаан тоосго	сая.ш	7.9	16.6	13.9	16.9	10.2	16.9
Хивс	мян.м ²	74.5	89.2	87.0	108.8	50.5	42.2
Сүлжмэл эдлэл	мян.ш	3412.1	4518.8	4214.3	2139.7	631.3	795.8
Эсгий	мян.м	19.5	21.9	26.7	20.5	21.9	37.7
Самнасан ноолуур	тн	581.9	1064.4	1554.7	1723.7	1587.0	824.7
Тэмээний ноосон хөнжил	мян.м	33.5	34.4	37.7	35.0	36.9	12.3
Сонин	сая.х.д.х	68.3	51.2	45.5	58.8	37.5	42.1
Ном, сэтгүүл	сая.х.д.х	23.6	22.9	27.6	41.7	49.6	56.6
Гурил	мян.т	53.7	57.2	62.2	55.1	93.3	127.1
Хүнсний давс	тн	1488.5	836.9	858.6	1046.5	1283.5	1746.2
Малын мах	мян.тн	0.5	2.7	3.0	9.4	15.2	9.8
Өлөн гэдэс	мян.гогц	264.1	270.9	123.2	144.2	543.2	881.7
Хиамны зүйл	мян.тн	1.1	1.0	1.2	1.5	1.5	1.5
Талх	мян.тн	18.1	16.4	15.5	21.1	19.7	16.7
Нарийн боов	мян.тн	5.9	7.7	9.5	10.0	9.9	9.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн	сая.л	3.7	3.8	5.1	7.1	10.0	16.9
Гоймон пүнтүүз	тн	910.5	1048.5	1437.1	2314.2	4488.0	2044.6
Архи, дарс	сая.л	3.4	3.3	4.2	7.8	13.0	16.8
Амтат ус, ундаа	мян.л	28751.8	23150.5	45386.7	45080.2	42015.3	67551.0


*-дахин

2005-2010 онд аж үйлдвэрийн гол нэрийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл тухайлбал, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, өлөн гэдэс, хүнсний давс, архи дарс, цахилгаан эрчим хүч, нүүрс, хайлуур жоншны баяжмал, улаан тоосго, сүлжмэл эдлэл, эсгий, сонин, ном, сэтгүүлийн үйлдвэрлэл 6.9-99.7 хувь өссөн байна.

БАРИЛГА

Нийслэл хотод 308 аж ахуй нэгж, байгууллага нийт 239.9 тэрбум төгрөгийн барилга угсралт их засврын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн жилийнхээс 30.9 хувиар өсчээ. Энэ нь Монгол улсад 2010 онд хийгдсэн барилга угсралт, их засврын ажлын 65.6 хувь нь болж байна. Нийслэл хотын барилга, угсралт засварын нийт гүйцэтгэлийн 97.7 хувийг шинэ барилга, өргөтгөлийн ажил, 2.3 хувийг их засврын ажил эзэлж байна.

Зураг 38. Шинэ барилга ба их засварын ажил, тэрбум төгрөг




Зураг 39. Барилгын төрөл, хувиар



Шинэ барилга, өргөтгөл шинэчлэлийн ажлын гүйцэтгэлийн 34.4 хувийг орон сууцны барилга, 28.1 хувийг орон сууцны бус барилгын ажил, 37.5 хувийг инженерийн барилга байгууламжийн ажил тус тус эзэлж байна. Нийт 5627.9.2 сая төгрөгийн их засварын ажил гүйцэтгэгдсэн бөгөөд 11.4 хувийг орон сууцны барилгийн засвар, 53.6 хувийг орон сууцны бус барилгын засвар, 35.0 хувийг инженерийн барилга байгууламжийн засварын ажил тус тус эзэлж байгаа юм.

Нийт 524.7 тэрбум төгрөгийн барилгын өртөг бүхий 315 барилга объект ашиглалтад оруулсан бөгөөд барилгыг өмчлөлийнх нь хувьд авч үзвэл төрийн өмчийн 18 хувь, хувь иргэний 10 хувь, хувийн хуулийн этгээдийн 72 хувь тус тус байна.

Зураг 40. Нийслэлд ашиглалтад орсон нийтийн орон сууц



Нийслэл хотод 2000-2010 онд нийт 42.0 мянга гаруй айлын орон сууцны барилга ашиглалтад орсон байна. 2010 онд 9.5 мянган айлын орон сууцны 132 барилга ашиглалтад орсон нь 2009 оныхоос 1.9 дахин, 2000 оноос бараг 10 дахин их байна.

Хүснэгт 31. Нийслэл хотод 2010 онд ашиглалтанд орсон барилга

Барилгын төрөл	Барилгын		Хүчин чадал	
	тоо	Өртөг, сая төгрөг	Хэмжих нэгж	хэмжээ
Орон сууцны барилга	132	342393.9	айл	9488
Үйлдвэрийн	7	28642.0	м ²	10823
Худалдаа үйлчилгээний	23	32653.8	м ²	22765
Зочид буудал	9	4144.0	орны тоо	830
Эмнэлэг	3	1050.0	орны тоо	60
Цэцэрлэг	7	3049.0	суудлын тоо	580
Сургууль	12	13817.6	суудлын тоо	9779
Соёл амралтын төв	13	4870.6		80
Оюутны байр	4	4880.0	оюутны тоо	3510
Номын сан	1	800.0		
Контор (албан тасалгааны зориулалттай барилга)	26	32161.6	м ²	29116
Агуулах, гараж, бусад	27	13701.7	м ²	1395
Эрчим хүчний	9	3118.9		
Авто зам	16	11331.9	км	24.04
Гүүр, гүүрэн гарц	2	2891.0	км	3.4
Далан, суваг, шугам сүлжээ	11	2003.7		25209
Зам талбайн ажил ба бусад	13	23209.9	м ²	21046

ДОТООД ХУДАЛДАА

Монгол улсын бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт 2010 онд урьдчилсан байдлаар 4918.7 тэрбум төгрөг байсан ба үүнээс 4174.6 тэрбум буюу 84.9 хувь нь нийслэл хотод дангаараа хийгдэж байна.


Худалдааны нийт борлуулалтын 79.6 хувийг бөөний, 20.4 хувийг жижиглэн худалдаа эзэлж байна.

Зураг 41.Худалдааны нийт борлуулалт,тэрбум төгрөг



Улаанбаатар хотод 2010 онд 3519 хүнсний дэлгүүр, 81 бөөний худалдааны төв, 22 зах, 791 түргэн үйлчилгээний цэгүүд жилийн турш үйл ажиллагаа явуулсан байна. Эдгээр худалдааны цэгт бөөний болон жижиглэнгийн нийт 4174.6 тэрбум төгрөгний худалдаа хийгдсэн нь 2007 оноос 2048.9 тэрбум буюу 96.4 хувь, 2008 оноос 991.4 тэрбум буюу 31.1 хувь, 2009 оноос 1396.4 тэрбум буюу 50.3 хувиар тус тус өссөн байна.

Зураг 42. Худалдааны нэг цэгт ногдох үйлчлүүлэгчийн тоо, аймаг, нийслэлээр




Хүснэгт 32. Бөөний болон жижиглэн худалдаа, тэрбум төгрөг

худалдаа	2008 он		Эзлэх хувь	2009 он		Эзлэх хувь	2010 он		Эзлэх хувь
	УБ	Улс		УБ	Улс		УБ	Улс	
Бөөний	1618.9	1982.3	81.7	1540.0	1850.9	83.2	3323.6	3374.2	98.5
Жижиглэн	1564.3	1807.3	86.6	1238.2	1488.3	83.2	851.0	1544.5	55.1
Бүгд	3183.2	3789.6	84.0	2778.2	3339.2	83.2	4174.6	4918.7	84.9


2010 онд Монгол улсын хэмжээнд худалдааны нийт борлуулалт 4918.7 тэрбум төгрөгт хүрсэн ба 84.9 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 15.1 хувь нь бусад аймгуудад үйл ажиллагаа явуулж байна.

Худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн 10.0 гаруй хувийнх нь жилийн борлуулалтын орлого 50 сая төгрөгнөөс дээш ба эдгээр ААН-ийн орлогын дүн худалдааны нийт борлуулалтын орлогын 90.0 гаруй хувийг эзэлдэг байна. Нийслэлийн худалдааны нийт цэгийн 79 хувь нь хүнсний дэлгүүр, 18 хувь нь түргэн үйлчилгээний цэг, 2 хувь нь бөөний худалдааны төв, үлдсэн 1 хувийг хүнсний болон барааны зах эзэлж байна.

Зураг 43. Худалдааны нийт борлуулалт, тэрбум төг



Зураг 44. Худалдааны цэг, төрлөөр



ГАЗАР ТАРИАЛАН

Нийслэлийн хэмжээнд 2010 онд 634.2 га талбайд төмс, 366.5 га талбайд хүнсний ногоо, 312.0 га талбайд тэжээлийн ургамал тариалав.

Нийт 597.2 га талбайгаас 4870.9 тонн төмс, 354.3 га талбайгаас 2566.3 тонн хүнсний ногоо, 312.0 га талбайгаас 504.5 тонн малын тэжээлийн ургамал хураан авч, 30480.9 тонн өвс хадлан, 497.5 тонн гар тэжээл, 91.8 тонн дарш бэлтгэсэн байна.

Нийслэлд газар тариалан эрхэлдэг 27 аж ахуйн нэгж, 22 төрийн болон төрийн бус байгууллага, 4907 өрх байна.

Нийт хураан авсан ургацын 42.1 хувийг аж ахуйн нэгж байгууллага, 57.9 хувийг иргэд хураажээ.

Хадлан тэжээл бэлтгэлийн 48.8 хувийг аж ахуйн нэгж байгууллага, 51.2 хувийг иргэд хураан авсан байна.

Хүлэмжийн ногоо 59.3 га талбайд тариалж, 314.0 тонн өргөст хэмх, 211.5 тонн улаан лооль хураан авч, 1 га талбайгаас 73.4 центнер ургац хураажээ.

Нийт хураасан ургацын 40.0 хувийг Сонгинохайрхан дүүрэг, 24.5 хувийг Хан-Уул дүүрэг, 35.5 хувийг бусад дүүрэг хураан авчээ.

Зураг 45. Төмс, хүнсний ногоо хураалт



Хүснэгт 33. Ургац хураалт, дүүргээр


	2008 он		2009 он		2010 он	
	Төмс	Хүнсний ногоо	Төмс	Хүнсний ногоо	Төмс	Хүнсний ногоо
Багануур	311.9	155.0	286.5	103.5	507.4	230.0
Багахангай	6.3	-	23.7	1.0	19.0	2.3
Баянгол	91.5	646.2	249.6	450.4	236.8	447.2
Баянзүрх	286.0	239.0	365.6	152.2	395.5	197.4
Налайх	122.8	104.7	157.7	82.5	94.0	29.1
Сонгинохайрхан	1432.3	511.0	1696.9	303.2	2560.6	414.2
Сүхбаатар	571.2	425.2	345.2	105.4	247.8	69.0
Хан-Уул	1179.3	692.5	793.4	478.9	732.6	1088.0
Чингэлтэй	78.0	87.0	79.5	91.5	77.2	89.1
Нийслэлийн дүн	4079.3	2860.6	3998.1	1768.6	4870.9	2566.3

Малтай өрх 2010 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор нийслэлийн мал бүхий 75 хороонд амины малтай 5482 өрх тоологдсон бөгөөд үүний 31.1 хувь буюу 1705 нь малчин өрх байна.

Хүснэгт 34. Малтай өрхийн тоо, дүүргээр

Дүүрэг	2008 он	2009 он	2010 он	Өсөлт, бууралт
Багануур	694	555	499	-10.1
Багахангай	147	181	181	-
Баянгол	4	4	4	-
Баянзүрх	1195	1293	1228	-5.0
Налайх	996	985	827	-16.0
Сонгинохайрхан	1558	1407	1355	-3.7
Сүхбаатар	386	368	320	-13.0
Хан-Уул	854	933	937	0.4
Чингэлтэй	168	150	131	-12.7
Нийслэлийн дүн	6002	5876	5482	-6.7

Зураг 46. Малтай өрхийн тоо



Малтай өрхийн тоо 2009 онд 5876 өрх байсан бол 2010 онд 5482 өрх болж 6.7 хувиар буюу 394 өрхөөр буурсан байна. 2010 онд Хан-Уул дүүргийн малтай өрхийн тоо 0.4 хувиар өсч, бусад дүүргийн малтай өрхийн тоо 3.7-16.0 хувиар буурсан байна.

Малчин өрх Эрчимжсэн мал аж ахуй, фермерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 1705 өрхийн 5304 малчид мал аж ахуй эрхэлж байгаа бөгөөд нийт малчдын 24.2 хувь нь 16-34 насны залуучууд, 42.6 хувь нь 35-59 насны эрэгтэй, 35-54 насны эмэгтэй, 33.1 хувийг тэтгэврийн насны хүмүүс эзэлж байна. Нийт малчдын 38.9 хувь буюу 2065 нь эмэгтэй малчид байна.


Нийслэлийн малчин өрхийн тоо өмнөх оноос 36.0 хувиар буюу 959 өрхөөр буурч, улсын хэмжээнд тоологдсон малчин өрхийн 1.1 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мал тооллогын дүнгээс 0.5 пунктээр бага байна.

Малчин өрхийн тоо буурсан гол шалтгааныг байгаль цаг уурын байдал эрс хүйтэрч, зуд болсон, малчид өөр аймаг, сумын нутагт өвөлжсөний улмаас тооллогод тэндээ хамрагдсан тухай эх сурвалжууд дурьдсан.

Хүснэгт 35. Малчин өрхийн тоо, дүүргээр

Дүүрэг	2008 он	2009 он	2010 он
Багануур	385	403	282
Багахангай	44	62	62
Баянгол	-	-	-
Баянзүрх	603	598	273
Налайх	323	341	286
Сонгинохайрхан	799	1054	598
Сүхбаатар	30	20	20
Хан-Уул	300	178	176
Чингэлтэй	10	8	8
Нийслэлийн дүн	2494	2664	1705

Зураг 47. Малчдын насны бүлэглэлт




Малчин өрхийн 98.0 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 91.6 хувь нь телевизортой, 13.4 хувь нь худагтай, 54.5 хувь нь автомашинтай, 20.0 хувь нь мотоциклтэй, 3.2 хувь нь трактортай өрх байна. 2009 онд нийт малчин өрхийн 92.4 хувь нь малын хашаатай байсан бол 2010 онд 100.0 хувь болж өмнөх оноос өссөн байна.

2010 онд нийслэлийн нэг малчин өрхөд дунджаар 106 толгой мал ногдож, малчин өрхөд ногдох малын тоогоор Багануур, Багахангай, Налайх дүүргүүд тэргүүлж байна.

Мал, тэжээвэр амьтдын тоо 2010 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор нийт 262881 толгой мал тоологдсон нь 2009 оноос 34.4 хувиар буюу 137944 толгой малаар буурсан байна. Монгол улсын хэмжээнд 2010 онд 32.7 сая толгой мал тоологдсон бөгөөд нийслэлийн мал 0.8 хувийг эзэлж байна.

Зураг 48. Нийслэлийн малын тоо



Хөдөө аж ахуйн салбараар авч үзвэл иргэдийн хувийн мал 256527 толгой, аж ахуйн нэгж, байгууллагын мал 6354 болж өмнөх оноос иргэдийн мал 135718 толгой буюу 34.6 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагын мал 2226 толгой малаар буюу 25.9 хувиар буурчээ.

Нийслэлийн малын тоог өмнөх онтой харьцуулахад тэмээ 19 толгой буюу 9.0 хувиар өсч, адуу 1179 толгой буюу 5.4 хувиар, үхэр 4631 толгой буюу 7.8 хувиар, хонь 66334 толгой буюу 39.5 хувиар, ямаа 65819 толгой буюу 43.5 хувиар буурчээ.

Хүснэгт 36. Малчдын ахуй, соёлын үзүүлэлт /дүүргээр/

Дүүрэг	Цахилгааны эх үүсвэртэй өрх	Телевизортой өрх	Малын хашаатай өрх	Худагтай өрх	Авто машинтай		Мотоциклтэй		Трактортай	
					өрх	тоо	өрх	тоо	өрх	тоо
Багануур	234	229	242	31	162	163	129	130	1	1
Багахангай	82	56	51	10	37	39	28	29	-	-
Баянзүрх	273	278	260	61	135	136	12	12	4	4
Налайх	280	202	286	19	98	98	45	45	-	-
Сонгинохайрхан	598	591	656	94	406	410	101	101	47	47
Сүхбаатар	20	20	20	-	6	6	1	1	-	-
Хан-Уул	176	177	183	13	85	88	19	19	3	3
Чингэлтэй	8	8	8	-	-	-	-	-	-	-
Нийслэлийн дүн	1671	1561	1706	228	929	940	335	337	55	55

2010 онд Баянгол дүүргийн малын тоо 23.1 хувиар өсч, бусад дүүргийн малын тоо 15.1-45.8 хувиар тус тус буурсан байна. Нийслэлд нийт тоологдсон малын тоогоор Багануур дүүрэг 83393 толгой малаар тэргүүлж байгаа бөгөөд өмнөх оноос 27833 толгой малаар буурсан байна.

Малын төрлөөр авч үзвэл үхрийн тоогоор Сонгинохайрхан дүүрэг, бусад малын төрөл дээр Багануур дүүрэг тэргүүлж байна. Харин хамгийн цөөн малтай нь Баянгол дүүрэг 32 толгой мал тоологдсон бөгөөд өмнөх оноос 23.1 хувиар өсчээ.

Хүснэгт 37. Малын тоо төрлөөр / сүүлийн жилүүдэд /

төрлөөр	1990 он	1995 он	2000 он	2005 он	2009 он	2010 он	өсөлт, бууралт	
							тоо	хувь
Малын тоо, бүгд	143578	294310	230639	247107	400825	262881	-137944	-34.4
Тэмээ	26	103	78	93	210	229	19	9.0
Адуу	16174	27750	20073	16835	21965	20786	-1179	-5.4
Үхэр	46176	64291	48576	50044	59540	54909	-4631	-7.8
Хонь	63160	145182	102809	94199	167906	101572	-66334	-39.5
Ямаа	18042	56984	59103	85936	151204	85385	-65819	-43.5
Хонин толгойд шилжүүлснээр*	469802	776979	588359	590115	816035	654519	-161516	-19.8

Хүснэгт 38. Малын тоо, байршлаар

Дүүргийн нэрс	2009 он	2010 он	үүнээс :					өсөлт, бууралт
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	
Багануур	111226	83393	162	5054	5571	43028	29578	-25.0
Багахангай	15541	10774	7	1235	825	4257	4450	-30.7
Баянгол	26	32	-	6	26	-	-	23.1
Баянзүрх	60402	38483	3	3045	11460	11706	12269	-36.3
Налайх	73219	39709	53	3262	7718	15908	12768	-45.8
Сонгинохайрхан	84804	56037	3	4507	18137	17824	15566	-33.9
Сүхбаатар	4523	3842	-	318	2528	348	648	-15.1
Хан-Уул	48665	29104	1	3331	7749	8363	9660	-40.2
Чингэлтэй	2419	1507	-	28	895	138	446	-37.7
Нийслэлийн дүн	400825	262881	229	20786	54909	101572	85385	-34.4

Амины малын тоо 2010 онд иргэдийн хувийн малын тоо 256527 толгой болж нийт малын 97.6 хувийг эзэлж байна. Нийт тоологдсон тэмээний 99.6 хувь, адууны 98.3 хувь, үхрийн 98.4 хувь, хонины 95.9 хувь, ямааны 98.9 хувийг хувийн аж ахуйн мал эзэлж байна.


Нийслэлийн малтай нэг өрхөд 48 толгой мал, хонин толгойд шилжсэнээр 119 толгой мал ногдож байгаа бөгөөд малтай өрхийн ам бүлийн нэг хүнд 15 толгой мал, хонин толгойд шилжсэнээр 37 бог мал ногдож байна. Малтай нэг өрхөд ногдох малын тоогоор Багануур дүүрэг /нэг өрхөд 167 толгой мал/ тэргүүлж байна.

Хүснэгт 39. Малчин өрхийн малын бүлэглэлт

Малын бүлэглэлт	Малчин өрх	Ам бүлийн тоо	Малын тоо	үүнээс :				
				тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
11-30 малтай	505	1634	8255	1	1019	5041	1082	1112
31-50 малтай	290	976	9965	0	1059	4418	1908	2580
51-100 малтай	379	1225	28308	2	2328	6885	9949	9144
101-200 малтай	306	1001	42321	40	2890	5717	16443	17231
201-500 малтай	181	628	56038	58	3534	3135	27314	21997
501-999 малтай	36	142	23410	0	1097	881	12735	8697
1000-1499 малтай	6	22	6690	0	527	159	4022	1982
1500-2000 малтай	1	5	1748	0	118	77	1175	378
2001-дээш малтай	1	5	3982	0	1678	183	1475	646
Дүн	1705	5638	180717	101	14250	26496	76103	63767

2010 онд малчин өрхийн малын тоонд бүлэглэлт хийсэн бөгөөд 1705 малчин өрхийн 180717 толгой мал тоологдсон байна. Энэ нь нийт тоологдсон малын 68.7 хувийг эзэлж байна. Нийслэлийн хэмжээнд малчин өрхийн нийт малын 31.0 хувийг 201-500 малтай өрхийн тоо эзэлж байна.

Зураг 49. Бойжуулсан төл



2010 онд 89494 хээлтэгч мал төллөж, 89799 төл гарсны 88.4 хувь буюу 79403 төл бойжиж байна. Бойжсон төлийн тоо өмнөх оноос 40.5 хувиар буюу 53936 толгойгоор буурчээ.

2010 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор 6883 төлийг худалдан авч, 28372 төлийг худалдсан байна.

Тооллогын дүнгээр нийт 10396 төл хорогдсон бөгөөд энэ нь өмнөх оноос 7 дахин өссөн байна. Нийслэл хотын дунджаар 100 эхээс 42 төл бойжуулсан байна. Үүний дотор 100 эхээс ботго 15, унага 48, тугал 59, хурга 41, ишиг 35-г тус тус бойжуулсан байна.

Хүснэгт 40. Төл бойжилт, төрлөөр

	2007 он	2008 он	2009 он	2010 он	үүнээс :				
					ботго	унага	тугал	хурга	ишиг
Гарсан төл	118472	117870	134815	89799	17	3517	17543	38220	30502
Бойжсон төл	116899	116600	133339	79403	12	3167	16777	33605	25842
Хорогдсон төл	1573	1270	1476	10396	5	350	766	4615	4660
Бойжилтын хувь	98.7	98.9	98.9	88.4	70.6	90.0	95.6	87.9	84.7

Том малын зүй бус хорогдол 2010 оны эхний малын 18.4 хувьтай тэнцэх 73927 толгой том мал зүй бусаар хорогдсон нь 2009 оноос 19.4 дахин өссөн байна.

Хүснэгт 41. Том малын зүй бус хорогдол, дүүргээр

Дүүргийн нэрс	2008 он	2009 он	2010 он	үүнээс :				
				тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Багануур	361	953	16363	5	399	818	8375	6766
Багахангай	132	34	5483	-	388	291	2433	2371
Баянгол	4	-	4	-	-	4	-	-
Баянзүрх	343	241	6796	-	215	627	2626	3328
Налайх	337	875	9244	2	201	851	4241	3949
Сонгинохайрхан	525	1492	14815	-	106	862	6675	7072
Сүхбаатар	156	42	377	-	14	36	102	225
Хан-Уул	247	166	20754	-	862	1373	8380	10139
Чингэлтэй	14	16	91	-	3	43	18	27
Дүн	2119	3819	73927	7	2188	5005	32850	33877

Нийт хорогдлын 3.0 хувийг адуу, 6.8 хувийг үхэр, 44.4 хувийг хонь, 45.8 хувийг ямаа, 7 тэмээ хорогджээ. Том малын зүй бус хорогдлын 2.4 хувь буюу 1796 толгой мал өвчнөөр, 97.0 хувь буюу 71689 толгой мал гэнэтийн аюулаар, 0.6 хувь нь бусад шалтгаанаар хорогджээ.

Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн мал 2002 онд нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх талаар авах арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2010 оны мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнд харьцуулж үзвэл 7.2 хувийг эзэлж, хориглох бүсийн малын тоо өмнөх оноос 26.6 хувиар буурсан байна. Хориглох бүсийн малын тоог өмнөх онтой харьцуулахад Баянгол дүүрэгт 23.1 хувиар өсч, Баянзүрх дүүрэгт 39.8 хувиар, Сонгинохайрхан дүүрэгт 16.0 хувиар, Сүхбаатар дүүрэгт 15.1 хувиар, Хан-Уул дүүрэгт 36.0 хувиар, Чингэлтэй дүүрэгт 37.7 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 42. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малын тоо, дүүргээр

Дүүргийн нэрс	2009 он	2010 он	үүнээс :				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Баянгол	26	32	-	6	26	-	-
Сүхбаатар	4523	3842	-	318	2528	348	648
Чингэлтэй	2419	1507	-	28	895	138	446
Баянзүрх (11,20-р хороо ороогүй)	5087	3061	-	80	982	801	1198
Сонгинохайрхан (20,21-р хороо ороогүй)	8559	7190	3	121	3199	1468	2399
Хан- Уул (12,13,14-р хороо ороогүй)	5218	3338	1	167	1239	812	1119
Хориглох бүсэд байгаа малын дүн	25832	18970	4	720	8869	3567	5810

Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малын 3.8 хувийг адуу, 46.8 хувийг үхэр, 18.8 хувийг хонь, 30.6 хувийг ямаа эзэлж, 4 тэмээ тоологджээ.

Нийслэлийн нийт мал сүргийн 30.2 хувийг буюу 79403 нь өсвөр насны мал, 52.8 хувийг буюу 138853 нь хээлтэгч мал, 16.8 хувийг буюу 44102 нь ажлын ба бэлтгэл насны эр мал, 0.2 хувийг буюу 523 нь хээлтүүлэгч мал байна.

Хөдөө аж ахуйн тэжээвэр амьтад Мал, тэжээвэр амьтдын тооллогоор 103 өрхийн 2361 гахай, 16 аж ахуйн нэгжийн 10550 гахай, 219 өрхийн 11287 шувуу үүнээс 10938 тахиа, 8 аж ахуйн нэгж, байгууллагын 267110 шувуу үүнээс 267021 тахиа, 2 илжиг, 23 өрхийн 180 туулай, 3 өрхийн 53 бүл зөгий тоологдсон байна. Өмнөх оны тооллогын дүнгээс гахайн тоо 4.7 хувиар, шувууны тоо 2.3 хувиар өсчээ.

Гахай, шувуу тэжээдэг иргэд, аж ахуйн нэгжүүд 2010 онд 187.1 тонн гахайн мах, 66.6 тонн шувууны мах, 38.5 сая ширхэг өндөг үйлдвэрлэж 7.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

2010 онд гахайн мах кг нь дунджаар 3950 төгрөг, шувууны мах 1500 төгрөг, өндөг ширхэг нь 180 төгрөг, зөгийн бал 1 кг нь 22200 төгрөгийн ханштай үйлдвэрээсээ гарсан байна.

Хүснэгт 43. Тэжээвэр амьтдын тоо, дүүргээр

Дүүргийн нэрс	Гахай	Шувуу	Үүнээс тахиа	Буга	Илжиг	Хүдэр	Туулай	Зөгий
Багануур	25	2451	2451	-	-	-	-	5
Багахангай	-	12	12	-	-	-	-	-
Баянгол	-	22	22	-	-	-	-	-
Баянзүрх	911	224	137	-	-	-	62	-
Налайх	179	482	482	-	-	-	8	48
Сонгинохайрхан	3632	22032	21925	-	-	-	83	-
Сүхбаатар	15	536	487	-	1	-	11	-
Хан-Уул	8121	252069	252069	-	-	-	-	-
Чингэлтэй	28	569	374	-	1	-	16	-
Нийслэлийн дүн	12911	278397	277959	-	2	-	180	53

2010 онд нийслэлийн хэмжээгээр 4907 өрх, 49 аж ахуйн нэгж, байгууллага нийт 30480.9 тонн байгалийн хадлан өвс, үүнээс иргэд өөрсдийн хүчээр 15619.9 тонн өвс, 497.5 тонн гар тэжээл, 91.8 тонн дарш бэлтгэсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад өвс хадлан 20.8 хувиар, тэжээл бэлтгэл 11.1 хувиар буурсан байна.


ТЭЭВЭР Авто тээврээр улсын хэмжээнд 2010 онд тээвэрлэсэн нийт зорчигчдын 89.5 хувь, тээсэн нийт ачааны 20.6 хувь нь нийслэл хотод тус тус ногдож байна. Тээсэн ачааны улсын дүнд нийслэл хотын эзлэх хувь 2010 онд өмнөх оноос 10.5 пунктээр буурсан бөгөөд 6-7 жилийн өмнөх үетэй харьцуулахад хоёр дахин өсөлттэй байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд буурах хандлага ажиглагдаж байна. Харин авто тээврээр тээвэрлэсэн зорчигчийн улсын дүнд нийслэл хотын эзлэх хувь хэмжээ 2007 оноос бусад онуудад дийлэнх буюу 80-аас дээш хувийг эзэлж байна.

Хүснэгт 44. Авто тээврийн үндсэн үзүүлэлт


Он	Тээсэн ачаа (мян.тн)		Улсын дүнд УБ хотын эзлэх хувь	Тээвэрлэсэн зорчигч (сая хүн)		Улсын дүнд УБ хотын эзлэх хувь
	Монгол Улсад	Нийслэл хотод		Монгол Улсад	Нийслэл хотод	
2010	12610.2	2596.7	20.6	246.7	220.7	89.5
2009	10563.8	3288.5	31.1	229.0	199.0	86.9
2008	9255.7	3075.1	33.2	226.9	193.0	85.1
2007	9207.1	3460.0	37.6	205.0	156.4	76.3
2006	9189.4	3405.2	37.1	190.7	154.4	81.0
2005	8081.7	964.5	11.9	188.2	153.2	81.4
2004	7561.9	760.3	10.1	189.6	152.3	80.3

Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ Улаанбаатар хотын дотор болон хот орчимд нийтийн тээврийн үйлчилгээг 2010 онд нийт 4.1 мянган км урт бүхий 134 чиглэлд 95 аж ахуйн нэгж, байгууллага үзүүлсэн байна.

Зураг 50. Зорчигчдын тоо, сая хүн төлбөрийн хэлбэрээр



Зураг 51. Үйлчилгээний орлого, тэрбум төг төлбөрийн хэлбэрээр



Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч ААНБ-ууд 2010 онд давхардсан тоогоор 220.7 сая хүн тээвэрлэж, 750.4 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, 56.3 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ. Өнгөрсөн оноос зорчигчдын тоо 10.9 хувиар, үйлчилгээний орлого 49.8 хувиар тус тус өссөн байна.

Нийслэлийн Тээврийн газрын зорчигч тээвэрлэлтийн тайлангаас үзэхэд үйлчилгээний нийт орлогын 52.6 хувийг шугамын орлого бүрдүүлж байгаа бөгөөд нийт зорчигчдын 59.6 хувь нь нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо тасалбар худалдан авч үйлчлүүлсэн байна.

2010 онд нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэлт их багтаамжийн автобус, троллейбус болон таксины үйлчилгээнд хийгдэж, нийтдээ 141 тээврийн хэрэгсэл (их багтаамжийн 85 автобус, 9 троллейбус, 47 такси) үйлчилгээнд шинээр гарч, харин нийтийн тээврийн үйлчилгээний стандартын шаардлага хангахгүй болж, 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 692 тээврийн хэрэгсэл (их, дунд багтаамжийн 112 автобус, бага оврын 558 автобус, 4 троллейбус, 18 такси) үйлчилгээнээс хасагджээ.

Хүснэгт 45. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж буй ААН-ийн тоо

Үзүүлэлт	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Аж ахуйн нэгжийн тоо	143	131	119	101	102	95
Төрийн өмчийн	4	3	3	3	3	3
Автобусны	3	2	2	2	2	2
Троллейбусны	1	1	1	1	1	1
Хувийн өмчийн	139	128	116	98	99	70
Их, дунд багтаамжийн автобустай	16	18	19	23	23	23
Бага оврын автобустай	71	68	62	54	55	47
Таксийн үйлчилгээний	52	42	35	21	21	22

Хүснэгт 46. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл

Үзүүлэлт	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Бүгд	1536	1552	1637	1846	1574
Автобус	272	371	454	604	675
Троллейбус	48	36	32	34	34
Микро автобус	484	476	500	447	345
Буухиа үйлчилгээ	715	641	617	716	451
Хот орчим	17	28	34	45	69


Нийтийн тээврийн үйлчилгээний шугаманд өдөрт дунджаар 1574 тээврийн хэрэгсэл ажиллаж, хоногт дунджаар 612.9 мянган зорчигч тээвэрлэжээ. Түүнчлэн өдөрт дунджаар 453 такси үйлчилгээнд ажиллаж байв.

Нийтийн тээврийн үйлчилгээний шугаманд өдөрт ажиллаж байгаа их багтаамжийн автобусны 30.4 хувийг төрийн өмчийн, 69.6 хувийг хувийн хэвшлийн ААНБ-ын тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Нийслэл хот дотор зорчих их багтаамжийн автобусны дундаж хурдны графикт хугацааг 19км/цагаар тогтоосон байдаг боловч Энхтайвны өргөн чөлөөний Баруун 4 замаас Зүүн 4 замын уулзварын хооронд оргил ачаалын үед тээврийн хэрэгслэлийн дундаж хурд буурч 10-11 км/цаг болсон байна.

Зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу хүлээлтийн дундаж хугацааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад их, дунд багтаамжийн автобус, троллейбусных 0.1-0.4 минутаар, бага оврын автобусных 1.6 минутаар тус тус багасчээ.

Зураг 52. Зорчигч тээврийн чиглэлийн урт



Зураг 53. Хүлээлтийн хугацаа, минут



Хүснэгт 47. Автобусны буудлын тоо, төвийн дүүргээр

Дүүрэг	2006 он		2007 он		2008 он		2009 он		2010 он	
	Нийт	Эцсийн зогсоол	Нийт	Эцсийн зогсоол	Нийт	Эцсийн зогсоол	Нийт	Эцсийн зогсоол	Нийт	Эцсийн зогсоол
Хан-Уул	58	8	58	8	58	8	79	6	73	10
Баянзүрх	130	25	133	26	133	26	132	16	140	24
Баянгол	86	9	86	9	86	9	56	1	61	6
Сүхбаатар	67	6	67	6	67	6	50	1	54	5
Чингэлтэй	58	8	58	8	61	9	114	13	115	14
Сонгинохайрхан	141	22	143	22	146	23	138	20	143	25
Нийт	540	78	545	79	551	81	569	57	586	84

Улаанбаатар хотод 2009 онд хийсэн үзлэгээр нийт автобусны зогсоолын 27.6 хувь нь зориулалтын зогсоолгүй, 82.6 хувь нь саравчгүй, 87.5 хувь нь нийтэд зориулсан сандалгүй, 78.0 хувь нь орчны гэрэлтүүлэггүй, 78.6 хувь нь автобусны зогсоолын тэмдэггүй байсан бөгөөд 192 зогсоол дээр үйлчилгээний цэг ажиллаж байв.

2010-2011 онд автобусны 100 хүртэл зогсоолын байгууламжийг барьж байгуулах талаар Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Нийтийн тээврийн газраас Худалдаа, хөгжлийн банктай хамтран ажилласан байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын ерөнхий менежерийн тушаалаар тохижуулалт хийх автобусны 100 зогсоолын байршлыг тогтоосны 27 нь Сүхбаатар, 18 нь Баянзүрх, 12 нь Хан-Уул, 11 нь Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянгол дүүргээс тус бүр 16 зогсоол сонгогджээ.


Худалдаа, Хөгжлийн банк сонгогдсон буудлын байгууламжийг өөрийн хөрөнгөөр өнгө үзэмж сайтай барьж, харьяалах дүүргийн Засаг даргын Тамгын газрын өмчлөлд шилжүүлж өгөх тул зогсоолын талбайд байршиж байгаа ТҮЦ-үүдийг нүүлгэж, газар чөлөөлөх арга хэмжээг авчээ.

2010 оны эцэст тус банкны хөрөнгө оруулалтаар 30 зогсоолд саравч, сандал, мэдээллийн самбар зэргийг барьж байгуулан, хогийн сав тавьж тохижуулсан байна.

Нийслэлийн Нийтийн Тээврийн газарт зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс 2010 онд дараах төрлийн нийт 934 санал гомдол ирсэний 88.8 хувийг нь шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 49 гомдол буюу 5.2 хувь нь хөнгөлөлтийн “2010” үнэмлэхээр явуулаагүй болон хүүхэд суулгаагүй, оюутны хөнгөлөлтийн картаар үйлчлээгүй тухай,
- 411 буюу 44.0 хувь нь үнэ тарифтай холбоотой, тасалбар олгоогүй, маршрут зөрчсөн, буудал дээр зогсоогүй, буудал зарлаагүй, цагийн хуваарь мөрдөөгүй тухай,
- 100 буюу 10.7 хувь нь хурд болон даац хэтрүүлсэн, стандартын шаардлага хангахгүй тээврийн хэрэгслээр үйлчилсэн, замын хөдөлгөөнд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаагүй оролцсон тухай,
- 374 буюу 40.1 хувь нь жолооч, мөнгө хураагчийн зан харьцаа, үйлчилгээний соёл, тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, өнгө үзэмж тааруу тухай

Зураг 54. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал гомдлын шийдвэрлэлт



Улаанбаатар хотын автомашины бүтэц


Нийслэлийн автомашины өсөлтийн хурдацыг сүүлийн 3 жилээр тооцож үзэхэд жилд дунджаар 20.6 хувийн өсөлттэй байна. Тухайн жилийн өсөлтөөр нь авч үзвэл автомашины жилийн дундаж өсөлт өнгөрсөн онд 23.0 хувьтай байсан бол 2010 онд 23.8 хувь болж нэмэгдэв.

Улаанбаатар хотод 2010 онд нийтдээ 162.7 мянган тээврийн хэрэгсэл техникийн хяналтын улсын үзлэгт хамрагдсан бөгөөд энэ нь Монгол Улсын хэмжээнд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 63.9 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 48. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины тоо

	2008 он	2009 он	2010 он	Автомашины тоо, төрлөөр				Иргэний хувийн автомашин		
				Суудлын	Ачааны	Автобус	Тусгай	2008 он	2009 он	2010 он
Нийслэлийн дүн	106848	131447	162710	118573	32344	9304	2489	77072	89577	130178
Багануур	1874	1656	1158	739	305	110	4	1594	1379	939
Багахангай	187	300	190	122	50	16	2	137	265	177
Баянгол	21635	26372	33643	24811	6546	1612	674	16810	16765	27235
Баянзүрх	21918	27060	38367	29006	7182	1858	321	16548	15418	31891
Налайх	1804	2235	1656	942	621	78	15	1555	1899	1529
Сонгинохайрхан	18303	22667	29731	21135	6265	2056	275	16381	19372	27284
Сүхбаатар	14452	19035	24446	17962	4498	1490	496	8314	12868	15673
Чингэлтэй	14084	17833	18425	13656	3382	1159	228	7973	11954	14187
Хан-Уул	10882	12675	15094	10200	3495	925	474	7760	9657	11263

Зураг 55. Автобус, овор хэмжээгээр, 2010 он



2010 оны техникийн хяналтын үзлэгийн нийслэлийн дүнгээс харахад нийт тээврийн хэрэгслийн 72.9 хувийг зөвхөн суудлын автомашин эзэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл нийслэлийн арван автомашин тутмын долоо нь суудлын автомашин байна. Суудлын автомашины 85.7 хувь нь иргэд, хувь хүмүүсийн эзэмшилд бүртгэлтэй байдаг байна. Нийт тээврийн хэрэгслийн 20 орчим хувийг эзэлж буй ачааны машины тоо 2010 онд 32.3 мянга болж өмнөх оноос 12.4 мянга гаруйгаар нэмэгджээ.

Нийслэлийн авто замын хөдөлгөөнд идэвхтэй оролцож буй нийт автобусыг овор хэмжээгээр нь ангилж үзвэл дийлэнх буюу 87.6 хувийг бага оврын гэж нэрлэгддэг бэсрэг автобус эзэлж байна. Харин дунд оврын буюу 8 метр болон түүнээс бага урттай автобус 3.5 хувийг эзэлдэг байна.

2010 онд нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэлт их багтаамжийн 85 автобусаар нэмэгдсэн боловч нийслэлийн хэмжээнд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автобусны арав хүрэхгүй хувь нь том оврын автобус (урт нь 8 метрээс дээш) байгаа ажээ.

Хүснэгт 49. Автомашины тоо, өмчийн хэлбэрээр, 2010 он

		Бүгд	Үүнээс: автомашины үндсэн төрлөөр			
			Суудлын	Ачааны	Автобус	Тусгай зориулалт
Нийслэлийн дүн		162710	118573	32344	9304	2489
Аж ахуйн нэгжийн автомашин	Төрийн болон орон нутгийн өмчийн	2591	1348	609	527	107
	Дипломат, олон улсын байгууллагын	413	309	61	42	1
	Төрийн бус байгууллагын	1966	939	523	183	321
	Компани, хоршоо, нөхөрлөлийн	27562	14343	9415	2313	1491
Амины автомашин		130178	101634	21736	6239	569

2010 оны техникийн хяналтын үзлэгийн нийслэлийн дүнгээр нийт тээврийн хэрэгслийн 20.0 хувь нь аж ахуй нэгж, байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байгаагийн 1.6 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн, 0.3 хувийг дипломат болон олон улсын байгууллагын, 1.2 хувийг төрийн бус байгууллагын, 16.9 хувийг компани, хоршоо, нөхөрлөлийн автомашин тус тус эзэлж байна.

Амины автомашин нийт тээврийн хэрэгслийн дийлэнх буюу 80.0 хувийг эзэлж байгаа бөгөөд 62.5 хувь нь суудлын, 13.4 хувь нь ачааны, 3.8 хувь нь автобус, 0.3 хувь нь тусгай зориулалтын автомашин байна.


Техникийн хяналтын 2010 оны улсын үзлэгээс эхлэн тээврийн хэрэгслийн ашигласан хугацааны ангилалд өөрчлөлт орсон бөгөөд Улаанбаатар хотод бүртгэгдсэн нийт тээврийн хэрэгслийн 23.9 хувийг 4-9 жил, 72.4 хувийг арав ба түүнээс дээш жилээр ашиглаж байгаа тээврийн хэрэгслүүд тус тус эзэлж байна. Энэ ангилалд харъяалагдаж буй 117.9 мянган тээврийн хэрэгслийн 64.0 хувь нь нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт ногдож байгаагийн дотор 10 ба түүнээс дээш жилээр ашигласан таван автомашин тутмын нэг нь Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт тус тус ногдож байна.

Үйлдвэрлэж гарсан хугацаанаас хойш 0-3 жил ашиглаж буй шинэ автомашины тоо нийт тээврийн хэрэгслийн дөнгөж 3.6 хувийг эзэлдэг байна. Уг ангилалд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн 49.5 хувь нь нийслэлийн Сүхбаатар (26.2%), Хан-Уул (23.3%) дүүргүүдэд байна.

Хүснэгт 50. Автомашин, үйлдвэрлэсэн он, дүүргээр

Дүүрэг	2009 он					2010 он			
	Бүгд	3 хүртэл жил	4 - 6 жил	7 - 10 жил	11-ээс дээш	Бүгд	0 - 3 жил	4 - 9 жил	10-аас дээш
Нийслэлийн дүн	131447	9462	15988	47720	58277	162710	5869	38911	117930
Баянзүрх	27060	2032	6025	11939	7064	38367	866	9274	28227
Хан-Уул	12675	1660	1386	1004	8625	15094	1365	3579	10150
Баянгол	26372	1141	1249	7785	16197	33643	1112	9018	23513
Сүхбаатар	19035	1690	1587	2906	12852	24446	1536	6821	16089
Сонгинохайрхан	22667	422	1724	17293	3228	29731	391	5579	23761
Чингэлтэй	17833	2091	3488	5126	7128	18425	575	4079	13771
Налайх	2235	20	244	900	1071	1656	14	287	1355
Багануур	1656	31	39	399	1187	1158	9	239	910
Багахангай	300	35	32	79	154	190	1	35	154

Зураг 56. Автомашин, шатахууны төрлөөр



Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн 162.7 мянган автомашиныг хөдөлгүүрийнх нь шатахууны төрлөөр ангилж үзэхэд 66.8 хувь нь “бензин хөдөлгүүр”-тэй автомашин эзэлж байгаа бөгөөд энэ төрлийн автомашины тоо 2009 оны дүнгээс 16.7 хувиар нэмэгджээ. Сүүлийн жилүүдэд газ болон цахилгаан хөдөлгүүртэй автомашины тоо өсөх хандлагатай байгаа хэдий ч дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 30 шахам хувийг эзэлсэн хэвээр байна.

Хүснэгт 51. Автомашины тоо, шатахууны төрөл, хүрдний байрлалаар, 2010 он

		Бүгд	Үүнээс: автомашины үндсэн төрлөөр			
			Суудлын	Ачааны	Автобус	Тусгай зориулалт
Нийслэлийн дүн		162710	118573	32344	9304	2489
Шатахууны төрөл	Бензин хөдөлгүүр	108671	102366	4486	1627	192
	Дизель хөдөлгүүр	48480	11466	27250	7470	2294
	Цахилгаан	1515	1447	46	21	1
	Газ	4044	3294	562	186	2
Хүрдний байрлал	Зүүн	75906	38049	26860	8727	2270
	Баруун	86804	80524	5484	577	219

Зураг 57. Марк үүсгэсэн улс, хувиар, 2010 он



2010 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн нийт автомашиныг марк үүсгэсэн улс орноор нь ангилж үзэхэд Япон болон БНСУ-д тухайн автомашины марк үүсгэгдсэн 143.5 мянган тээврийн хэрэгсэл байгаа нь нийт автомашины дийлэнх буюу 88.2 хувийг эзэлж байна.

ОХУ (7.0 мян), Хятад (5.7 мян), Герман (3.3 мян) улсад марк нь үүсгэгдсэн тээврийн хэрэгслүүд эхний тавд орж нийт автомашины 9.8 хувьтай тэнцэж байна.


Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины 0.9 хувийг эзэлж буй 1491 тээврийн хэрэгслийн марк үүсгэсэн улс нь АНУ бөгөөд жагсаалтын зургаад оржээ. Автомашины марк үүсгэсэн бусад улс орнуудад Испани, Румын, Польш, Канад, Латви, Швейцарь зэрэг улс багтаж байна.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ 2010 онд нийслэлийн шуудан, харилцаа холбоо, интернэтийн үйлчилгээний салбарын орлого 392.2 тэрбум төгрөг болж, үүнээс хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс орсон орлого 310.6 тэрбум төгрөгт хүрч, 2009 онтой харьцуулахад үйлчилгээний орлого 39.9 тэрбум төгрөг буюу 11.1 хувиар нэмэгдэв. Нийт орлогод хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс орсон орлогын эзлэх хувь өмнө оныхоос 7.1 пунктээр буурсан байна.


Хүснэгт 52. Холбооны салбарын үндсэн үзүүлэлт,

	2008 он		2009 он		2010 он	
	Улс	Нийслэл	Улс	Нийслэл	Улс	Нийслэл
Нийт орлого, оны үнээр, сая төг	343405.0	330555.9	380058.6	352354.3	401631.1	392279.2
Үүнээс: хүн амын орлого, сая төг	297355.3	291165.3	309159.3	303947.9	315027.5	310680.9
Суурин телефон цэг, мянга	151.6	95.4	142.9	94.9	143.2	98.8
Үүнээс: айл өрхийн	108.2	67.8	97.4	63.8	97.1	65.3
Утасгүй телефон, тоо	35404	33173	45490	42212	45461	41473
Үүрэн телефон хэрэглэгч, мянга	1745.9	1364.3	2208.7	1798.5	2532.9	2102.8
КаТВ-ийн хэрэглэгч, тоо	101332	80780	112921	89912	120551	95262

Зураг 58. Суурин телефон цэгийн тоо



Зураг 59. Суурин телефон хэрэглэгч, хувийн жин



2010 онд нийслэл хотын суурин телефон цэгийн тоо 98.8 мянга болж, улсын хэмжээнд байгаа нийт суурин телефон цэгийн 69.0 хувийг эзлэх болов. Нийслэлийн суурин телефон цэгийн тоо өмнөх оныхоос 4.2 хувиар, үүний дотор телефон утастай айл өрхийн тоо 2.3 хувиар өссөн нь сүүлийн 5-6 жилд гараагүй өөрчлөлт байв.


Суурин телефон хэрэглэгчдийн тоог эзэмшигчийнх нь төрлөөр ангилж үзвэл телефон утастай айл өрхийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 1.2 пунктээр буурч, нийт телефон цэгийн 66.1 хувийг эзлэх болжээ. Энэ нь үүрэн холбоог эзэмшигч иргэдийн тоо эрс нэмэгдэж байгаагаас шалтгаалан суурин утасны зах зээлийг төсөвт болон бизнесийн бусад байгууллагууд эзэмших болсонтой холбоотой.

Тухайлбал, нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа суурин телефон цэгийн 13.2 хувийг төсөвт байгууллагууд эзэмшиж, суурин телефон хэрэглэгчдийн дүнд эзлэх хувийн жин нь өмнөх оныхоос 0.4 пунктээр нэмэгдсэн байхад 20.7 хувийг бизнесийн болон бусад байгууллагууд эзэмшиж, хувийн жин нь өмнөх оныхоос 0.8 пунктээр тус тус өссөн байна.

Хүснэгт 60. Мэдээлэл, холбооны зарим үзүүлэлт


Он	1000 хүн тутамд ногдох					
	суурин телефон цэг		интернетийн байнгын хэрэглэгчид		үүрэн телефон хэрэглэгчид	
	Улс	УБ хот	Улс	УБ хот	Улс	УБ хот
2010	52	87	72	144	918	1853
2009	53	87	39	78	815	1654
2008	57	91	16	35	657	1304
2007	57	91	11	25	449	924
2006	61	96	10	22	299	598

Зураг 61. Хөдөлгөөнт холбооны хэрэглэгч



2010 онд Монгол Улсын хэмжээнд үүрэн телефон холбооны бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо 2532.9 мянгад хүрсэн бөгөөд идэвхтэй хэрэглэгчдийн эзлэх хувийн жин 81.8, гар утасны давхардсан хэрэглээтэй хүн амын эзлэх хувь 19.7 болсон нь дэлхийн дунджаас 5.0 пунктээр илүү байна. Үүрэн телефон эзэмшиж байгаа нийт хэрэглэгчдийн 83.0 хувь буюу 2102.8 мянган хэрэглэгч нь нийслэл хотод байна.

Зураг 62. Үүрэн холбооны хэрэглэгчид, мян хүн



Үүрэн холбоо эзэмшиж буй нийслэлийн иргэдийн 251.0 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1851.8 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. Түүнчлэн нийслэлд 41.5 мянга орчим хэрэглэгч утасгүй суурин телефон буюу WLL үйлчилгээг, 0.8 мянган хүн сансарын холбоог эзэмшиж байна. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоон үзүүлэлтээр улсын дүнд нийслэл хотын эзлэх хувь хэмжээ 2004-2008 онуудад 75.4-79.1 хувийн хооронд хэлбэлзэж байв.

Учир нь хөдөө, орон нутагт үүрэн телефон үйлчилгээний хамрах хүрээ өргөжиж, хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн тул энэ үзүүлэлт 2006 онд 75.4 хувь болтлоо буурч байсан бөгөөд 2009 онд анх удаагаа 81.4 хувьд хүрч өмнөх оныхоос 3.3 пунктээр өсч байв. Энэ байдал 2010 онд ч хэвээр хадгалагдаж үүрэн телефон хэрэглэгчдийн тоогоор улсын дүнд нийслэл хотын эзлэх хувийн жин 83.0 хувь болж, өмнөх оныхоос 1.6 пунктээр нэмэгдээд байна.

Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн хэрэглэгчдийн судалгаагаар нийслэлчүүдийн 92 хувь нь өдөр бүр телевиз үзэж, удаад нь интернэт ашиглаж байгаа бол дөрвөн хүн тумын нэг нь радио сонсдог байна. 2010 онд нийслэл хотод 2 радио (Хамаг Монгол FM95.1, Элгэн нутаг FM96.9) шинээр нэмэгдсэнээр орон даяар нэвтрүүлгээ хүргэдэг Монголын Үндэсний Олон нийтийн радиогоос гадна Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг 26 радио үйл ажиллагаа явуулав. Радио нэвтрүүлэг дамжуулж буй хэлбэрийн хувьд 92.6 хувь нь хэт богино долгионы радио байгаа бөгөөд талаас илүү хувь нь 24 цагийн турш ажиллаж, цэнгээнт болон танин мэдэхүй, дуу хөгжим, мэдээллийн хөтөлбөрөө нийслэлийн сонсогчдод хүргэж байна.

Нэвтрүүлгээ Улаанбаатар хотын хэмжээнд цацдаг радиогийн 18 нь хувийн, 30.8 хувь нь төрийн бус байгууллагын харьяалалд болон олон нийтийн статустай бөгөөд 7 хоногийн нэвтрүүлгийн цаг нь нийтдээ 3500 гаруйд хүрчээ.

Хүснэгт 54. Радиогийн үндсэн үзүүлэлт

	Радио станцын тоо	Үүнээс: FM радио	7 хоногийн нэвтрүүлгийн цаг	Үүнээс:		
				МҮОН-ийн радио	Улаанбаатар радио	FM радио
2005 он	21	19	2826	126	24	2676
2006 он	21	19	2950	119	24	2807
2007 он	21	18	3046	119	24	2903
2008 он	22	20	3080	119	28	2933
2009 он	25	23	3123	119	24	2980
2010 он	27	25	3581	119	24	3438

Хүснэгт 55. Телевизийн үндсэн үзүүлэлт

	Телевизийн байгууллага	Үүнээс: Хувийн	Сувгийн тоо	7 хоногийн нэвтрүүлгийн дундаж цаг
2005 он	8	6	8	104
2006 он	17	15	18	100
2007 он	18	15	21	103.4
2008 он	19	16	23	110.2
2009 он	25	21	33	113.2
2010 он	28	26	40	115.4

Телевизийн тоо сүүлийн арваад жилийн турш байнга нэмэгдэж ирсэн бөгөөд энэ хандлага 2010 онд ч хэвээр үргэлжилж нийслэлд шинэ телевизүүд (Эх орон ТВ, ETV, Шууд ТВ) бий болж, UBS телевизийн 3-р суваг нэвтрүүлгээ цацаж эхэлсэн байна. Улмаар 2010 онд найман телевиз (NTV, Eagle TV, C1, SBN, TV8, TM, BTV, Эх орон телевиз) нэвтрүүлгээ сансарын антены тусламжтайгаар орон нутагт хүргэх боломжтой болсоноор үндэсний хэмжээнд цацагддаг телевизийн тоо 14 болж нэмэгджээ.

Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацаж буй телевизүүдийн дөрөв нь 2 сувагтай, нэг нь 3 сувагтай үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс гурав нь Багануур, Налайх дүүрэгт, хоёр нь нийслэлд төдийгүй Дархан, Эрдэнэт хотод нэвтрүүлгээ хүргэж байна. Түүнчлэн бие даан нэвтрүүлэг бэлтгэн кабелийн сувгаар цацдаг 7 суваг нийслэлийн


хэмжээнд ажиллаж байгаа бөгөөд эдгээрийн 3 нь (Dream, Mongolian Top Music, Moncinema) 2010 онд шинээр байгуулагдаж, сувгийн тоо нийтдээ 40 болов.

Үүрэн холбооны оператор Скайтель, Мобиком компанийн хэрэглэгчид гар утсаараа нэвтрүүлгийг нь хүлээн авах боломжтой телевиз 2009 онд дөрөв байсан бол энэ тоо 2010 онд тав (TV9, MN25, C1, МҮОНТ, NTV) болж нэгээр нэмэгдэв.

Хүснэгт 56. Нийслэлийн телевизортой өрх

Дүүрэг	Телевизортой өрх, бүгд				Үүнээс: Гэртээ нэг телевизортой өрх			
	2007 он	2008 он	2009 он	2010 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Хан-Уул	22486	25062	27180	30521	20870	22903	24787	27531
Баянзүрх	49673	54489	62487	65929	46460	48146	54764	59045
Баянгол	34955	38364	43487	46864	29075	32234	36178	37390
Сүхбаатар	28674	29960	32800	35134	26348	28220	28402	30318
Чингэлтэй	28274	28299	30988	34761	26511	25285	27133	30191
Сонгинохайрхан	47043	49514	54009	56463	42536	44992	49555	52603
Налайх	7150	7724	8312	8645	6718	7342	7883	8209
Багануур	6162	6957	7034	7345	5764	6086	6210	6207
Багахангай	861	852	942	953	795	697	756	859
Улаанбаатар	225278	241221	267239	286615	205077	215905	235668	252353

Зураг 63. КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч



Хүснэгт 57. КаТВ-ийн хэрэглэгч

	Монгол Улс	УБ хот	Улсын дүнд УБ хотын эзлэх хувь
2010	120551	95262	79.0
2009	112921	89912	79.6
2008	101332	80780	79.7
2007	89689	72006	80.3
2006	81808	65912	80.6
2005	77277	60241	78.0

2010 онд нийслэлийн нийт өрхийн 97.4 хувь буюу 286.6 мянган өрх телевизортой байсан бөгөөд эдгээр өрхийн 88.0 хувь нь нэг телевизортой ажээ. Телевизортой гурван өрх тутмын нэг нь сууцны тусдаа байшинд, 40.2 хувь нь нийтийн зориулалттай орон сууцанд, 26.0 хувь буюу 74.4 мянган өрх нь монгол гэрт амьдарч байв. Нийслэлийн Хан-Уул, Баянгол дүүргийн нийт өрхийн 99.5-99.6 хувь нь телевизортой байгаа нь нийслэлийн төвийн дүүргүүдийн хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Удаад нь Чингэлтэй (99.2%), Сүхбаатар (97.1%), Сонгинохайрхан (97.0%), Баянзүрх (94.1%) дүүргүүд орж байгаа юм.

Монгол Улсын хэмжээнд кабелийн телевизийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн ихэнх буюу 79.0 хувь нь нийслэл хотод байна. Кабелийн телевизийн хэрэглэгчдийн

тоо жил ирэх тутамд өсөн нэмэгдэж байгаа хэдий ч улсын дүнд нийслэл хотын эзлэх хувь 2010 онд өмнөх оныхоос 0.6 пунктээр буурсан байна. 2010 онд нийслэлийн хэмжээнд кабелийн 11 телевизээр 95.2 мянга гаруй хэрэглэгч үйлчлүүлсэний 94.2 хувь нь айл өрх байна. Тогтмол үйл ажиллагаа явуулсан кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс 9 нь хотын төвийн дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж, үзэгчдэд 48-70 хүртэл (хотын захын дүүрэгт 25-49) сувгаар нэвтрүүлэг дамжуулж цацжээ. Кабелийн телевизийн айл өрхөд үзүүлсэн үйлчилгээний сарын хураамж 3000-5500 төгрөг байв.

2010 онд нийслэлийн нийт өрхийн 31.7 хувь нь буюу 93.4 мянган өрх гэртээ компьютертэй болсон байна. Эдгээр өрхийн 64.7 хувь буюу 60.5 мянга шахам нь нийтийн зориулалттай орон сууцанд, 10.4 хувь буюу 9.7 мянган өрх монгол гэрт амьдардаг байна. Гэртээ компьютертэй нийт өрхийн 39.5 хувь буюу 36.9 мянга гаруй өрх интернэтэд холбогджээ. Интернэтэд холбогдсон нийт өрхийн 88.9 хувийг нийтийн зориулалттай орон сууцанд амьдардаг өрх эзэлж байна.

Зураг 64. Интернэтийн тусгай зөвшөөрөлтэй ААНБ



Нийслэлд интернэтийн үйлчилгээ (Internet service provider) эрхлэх тусгай зөвшөөрлийг 55 аж ахуйн нэгж, байгууллага эзэмшиж байгаагийн 38 нь тогтмол үйл ажиллагаа явуулж, интернэтийн “байнгын хэрэглэгч”-ийн тоо 2010 онд 162.5 мянга болжээ. Энэ нь улсын хэмжээнд байгаа интернэтийн байнгын хэрэглэгчдийн 81.3 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 58. Компьютертэй болон интернэтэд холбогдсон өрх

Дүүрэг	Компьютертэй өрх, бүгд				Үүнээс: Интернэтэд холбогдсон өрх			
	2007 он	2008 он	2009 он	2010 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Хан-Уул	4917	4843	6865	10011	971	1592	2324	4382
Баянзүрх	8651	11786	15276	21665	2171	2975	4615	6475
Баянгол	9866	15412	20546	25270	2226	5217	8285	12043
Сүхбаатар	6690	8883	11866	14286	954	1862	4238	6778
Чингэлтэй	5132	6864	8169	8686	794	1746	2249	2610
Сонгинохайрхан	4862	5864	8152	11072	468	583	1546	4028
Налайх	381	1011	1171	1303	31	262	317	298
Багануур	318	738	923	1060	6	338	307	304
Багахангай	38	46	77	67	4	6	8	9
Улаанбаатар	40855	55447	73045	93420	7625	14581	23889	36927

БОЛОВСРОЛ Монгол Улсын ерөнхий боловсролыг 2010-2011 оны хичээлийн жилээс эхлэн 12 жилийн тогтолцоонд шилжүүлснээс хойш сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын шинэ стандартаар 4 дахь жилдээ хичээллэж байна.

2010-2011 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 240.8 мянган хүүхэд, залуучууд суралцаж, 20.4 мянган багш, сурган хүмүүжүүлэгч, ажилчид ажиллаж байна. Өмнөх хичээлийн жилээс сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо 7.5 мянгаар, ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо 0.2 мянгаар өсчээ.

Хүснэгт 59. СӨБ-ын болон ерөнхий боловсролын байгууллагын зарим үзүүлэлт

Хичээлийн жил	Үзүүлэлт	Сургуулийн өмнөх боловсрол	Ерөнхий боловсролын сургууль
2005-2006	Сургалтын байгууллагын тоо	218	190
	Суралцагчдын тоо	41660	186186
	Үндсэн багшийн тоо	1399	7666
2006-2007	Сургалтын байгууллагын тоо	211	200
	Суралцагчдын тоо	37231	185192
	Үндсэн багшийн тоо	1560	7776
2007-2008	Сургалтын байгууллагын тоо	228	210
	Суралцагчдын тоо	38926	184265
	Үндсэн багшийн тоо	1398	8231
2008-2009	Сургалтын байгууллагын тоо	237	207
	Суралцагчдын тоо	44705	185018
	Үндсэн багшийн тоо	1780	8821
2009-2010	Сургалтын байгууллагын тоо	256	209
	Суралцагчдын тоо	48736	184351
	Үндсэн багшийн тоо	1795	9126
2010-2011	Сургалтын байгууллагын тоо	275	206
	Суралцагчдын тоо	56211	184595
	Үндсэн багшийн тоо	1835	9271

Сургуулийн өмнөх боловсрол 2010-2011 оны хичээлийн жилд нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 275 хүүхдийн цэцэрлэгийн 174 нь төрийн өмчийн, 101 нь хувийн өмчийн цэцэрлэгүүд байна.

Эдгээр цэцэрлэгийн үндсэн бүлэгт 52.0 мянган хүүхэд, хувилбар сургалтад 4.2 мянган хүүхэд, нийт 56.2 мянган хүүхэд багачууд сурч хүмүүжиж байгаа бөгөөд 5.5 хувь буюу 3.0 мянга нь 2 хүртлэх настай хүүхэд байна.

Зураг 65. Цэцэрлэгт хамрагдалтын хувь



Нийслэлийн хэмжээгээр 2-5 насны цэцэрлэгт хамрагдвал зохих нийт хүүхдийн 69.8 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна. Хувийн өмчийн цэцэрлэгүүдэд нийт 7794 хүүхэд сурч хүмүүжиж байгаа нь өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад 1214 хүүхдээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллаж буй үндсэн багшийн тоо 1.8 мянгад хүрч, цэцэрлэгийн нэг багшид дунджаар 30.6 хүүхэд ногдож байна.

Улсын дундажтай харьцуулахад нийслэлийн цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо дунджаар 4 хүүхдээр олон байна.

Бага, дунд боловсрол


2010-2011 оны хичээлийн жилд нийслэлд ерөнхий боловсролын 206 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд төрийн бус өмчийн сургуулийн тоо 96 буюу нийт сургуулийн 46.6 хувийг эзэлж байна. Нийт ЕБС-иудын 66.0 хувь нь нийслэлийн Сүхбаатар, Баянгол, Баянзүрх дүүргүүдэд төвлөрч байна. Төрийн бус өмчийн сургуулийн тоогоор Сүхбаатар, Баянгол дүүргүүд бусад дүүргүүдээс олон байгаа бахувийн сургуулиудын 58.3 хувь нь тус 2 дүүргийн нутаг дэвсгэрт байршин сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Энэ хичээлийн жилд улсын хэмжээний суурь боловсролын хамран сургалтын бохир жин 94.8 хувь, бага боловсролынх 98.6 хувь, дунд боловсролынх 94.7 хувьтай байна.

Зураг 66. ЕБС-ийн сургуулийн тоо, дүүргээр



Улаанбаатар хотод суурь боловсролын хамран сургалтын бохир жин 92.8 хувь, бага боловсролынх 97.5 хувь, харин бүрэн дунд боловсролын хамран сургалт 93.8 хувьтай байв.

Зураг 67. ЕБС-ийн 1-р ангид шинээр элсэгчид



Улсын дундажтай харьцуулахад анхан шатны боловс-ролын хүртээмж Улаанбаатар хотод өндөр байна. БСШУЯ-наас гаргасан албан ёсны мэдээгээр нийслэлийн хэмжээнд 1-5-р ангид 96582 хүүхэд суралцаж байгаа бөгөөд 2010-2011 оны хичээлийн жилд 1-р ангид 17398 хүүхэд шинээр элсэн орсон байна. Өмнөх хичээлийн жилээс 1372 буюу 7.9 хувь, 2008-2009 оны хичээлийн жилээс 4581 буюу 26.3 хувь, 2007-2008 оны хичээлийн жилийнхээс 2827 буюу 16.2 хувиар

буурчээ. Насны хувьд 85.1 хувийг 6 настай хүүхэд, 8.9 хувийг 7 настай хүүхэд эзэлж байна. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 1-р ангид шинээр элсэгчдийн тоо 7.9 хувиар буурч, нийт элсэгчдийн 49.1 хувь нь эмэгтэй хүүхэд байв.

Хүснэгт 60. ЕБС-ийн сургуулийн тоо, хичээлийн жил бүрээр

Хичээлийн жил		2005-2006	2006-2007	2007-2008	2008-2009	2009-2010	2010-2011
Он		2005	2006	2007	2008	2009	2010
Сургуулийн тоо		190	200	210	207	209	206
Үүнээс: Төрийн өмчийн		95	97	104	103	108	110
Төрийн бус өмчийн		95	103	103	104	101	96
ЕБС-ийн ангилал	Бага сургууль	15	11	11	11	12	9
	Үүнээс: төрийн бус өмчийн	12	10	9	10	11	8
	Дунд сургууль	84	10	8	5	5	7
	Үүнээс: төрийн бус өмчийн	43	6	3	4	2	2
	Ахлах сургууль	91	164	176	176	176	173
	Үүнээс: төрийн бус өмчийн	40	87	91	90	88	86
	Цогцолбор сургууль	-	15	15	15	16	17

Сүүлийн жилүүдийн хамран сургалтын түвшинг авч үзвэл тогтвортой бус байна. Энэхүү хэлбэлзэлд нөлөөлж буй голлох шалтгаан нь амьдралын түвшний доройтлоос үүдсэн сургууль завсардалт юм. 2010-2011 оны хичээлийн жилд ЕБС-д суралцдаггүй 6-14 насны 263 хүүхэд бүртгэгдсэн бөгөөд тэдний 111 нь эмэгтэй хүүхэд, 53.6 хувь нь сургуульд ороод завсардсан хүүхдүүд байна.

ЕБС-д суралцдаггүй нийт хүүхдүүдийн 142 нь 6-11 насныхан , 121 нь 12-14 насныхан байгаа бөгөөд 44.1 хувь нь амьдралын гачаалын улмаас сургууль завсардсан байхад 8.4 хувийнх нь шалтгаан тодорхойгүй ажээ. Бага боловсролын хамран сургалтыг дээшлүүлэх нэг гол асуудал нь сургууль завсардалтыг арилгах бөгөөд үүний тулд амьдралын гачигдал, сургууль, багш нарын болон хүүхдийн харилцааны зөрчил, үл ойлголцол, сургалтын арга барил, шилжилт хөдөлгөөн, эрүүл мэнд, өвчлөл зэрэг олон хүчин зүйлүүдийн нөлөөллийг судалж, холбогдох арга хэмжээг авах шаардлагатай юм.

Хүснэгт 61. ЕБС-ийн суралцагчдын тоо, улс, нийслэлээр, мянган хүн

Хичээлийн жил	2006-2007	2007-2008	2008-2009	2009-2010	2010-2011
Он	2006	2007	2008	2009	2010
Нийт суралцагчдын тоо	542.5	537.5	532.1	522.1	512.2
Үүнээс: эмэгтэй	276.7	273.3	269.2	262.6	257.3
УБ хотод суралцагчдын тоо	185.2	184.2	185.0	184.4	184.6
Үүнээс: эмэгтэй	94.8	93.7	93.3	92.3	92.4
Төрийн өмчийн сургуульд суралцагчид	166.9	164.6	164.2	165.3	165.5
Үүнээс: эмэгтэй	85.5	83.8	83.0	82.9	83.0
Төрийн бус өмчийн сургуульд суралцагчид	18.3	19.6	20.8	19.0	19.1
Үүнээс: эмэгтэй	9.3	9.9	10.3	9.4	9.4

Нийт бүх ЕБС-иудад 512.2 мянган хүүхэд суралцаж байгаагаас нийслэлийн ЕБС-иудад 184.6 мянган хүүхэд суралцжээ. Төрийн бус өмчийн сургуульд нийтдээ 19.1 мянган хүүхэд суралцсан нь өмнөх хичээлийн жилээс 0.5 хувиар өсчээ.

Нийслэлийн ЕБС-ийн нийт суралцагчдын 92.4 мянга буюу 50.1 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байна. Мөн нийт суралцагчдаас 96.6 мянган хүүхэд I-V, 59.7 мянга нь VI-IX, 28.3 мянган хүүхэд ахлах буюу X-XII ангид суралцжээ.

Хүснэгт 62. ЕБС-д ажилладаг багш нарын тоо, улс, нийслэлээр, мянган хүн

Хичээлийн жил	2006-2007	2007-2008	2008-2009	2009-2010	2010-2011
Он	2006	2007	2008	2009	2010
Нийт үндсэн багшийн тоо	22.9	23.9	25.5	26.1	26.4
Үүнээс: эмэгтэй	18.6	19.5	20.8	21.3	21.6
УБ хотын үндсэн багшийн тоо	7.8	8.2	8.8	9.1	9.3
Үүнээс: эмэгтэй	6.5	6.9	7.4	7.7	7.9
Төрийн өмчийн сургуулийн багшийн тоо	6.5	6.9	7.4	7.7	7.9
Үүнээс: эмэгтэй	5.5	5.9	6.3	6.6	6.7
Төрийн бус өмчийн сургуулийн багшийн тоо	1.3	1.3	1.4	1.4	1.4
Үүнээс: эмэгтэй	1.0	1.1	1.1	1.1	1.1

Манай улсын ЕБС-иудад 2010-2011 оны хичээлийн жилд 26.4 мянга гаруй багш ажиллаж байгаагаас 9.3 мянга гаруй нь нийслэлийн ЕБС-иудад ажилласан байна.

Хүснэгт 63. ЕБС-ийн нэг багшид ногдох сурагчдын тоо, улс, нийслэлээр

Хичээлийн жил	2006-2007	2007-2008	2008-2009	2009-2010	2010-2011
Он	2006	2007	2008	2009	2010
Улсын дундаж	23.7	22.5	20.8	20.0	19.8
Улаанбаатар	23.8	22.4	21.0	20.2	19.9

2010-2011 оны хичээлийн жилд нийслэлийн ЕБС-ийн нэг багшид ногдох сурагчдын тоо 19.9 болж 2009-2010 оны хичээлийн жилийнхээс 0.3-аар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Улсын дундажтай харьцуулахад ойролцоо үзүүлэлтэй гарсан байна.

Дээд боловсрол 2010-2011 оны хичээлийн жилд нийслэлийн нутаг дэвсгэрт 110 их дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулснаас төрийн өмчийн 15, төрийн бус өмчийн 91, гадаадын салбар сургууль 4 байв. Түүнчлэн шаталсан сургалт явуулдаг Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 10 төв үйл ажиллагаа явуулж тэдгээрт 19.0 мянган оюутан суралцсан байна.(Олгож буй боловсролын түвшнээс хамааран шаталсан сургалт явуулдаг зарим нэг МСҮТ-үүд дээд сургууль, коллежийн тоонд орсон болно.)

Хүснэгт 64. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн боловсролын сургуулиуд, төрлөөр

	Сургууль, төрлөөр	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
1	Бүгд, үүнээс:	140	136	136	131	125	110
1.1	Мэргэжлийн анхан болон дунд шатны боловсрол олгох	3	4	9	10	10	10
	Төрийн өмчийн	2	2	1	1	1	1
	Төрийн бус өмчийн	1	2	8	9	9	9
1.2	Их сургууль	11	13	13	13	13	12
	Төрийн өмчийн	8	10	10	10	9	8
	Төрийн бус өмчийн	3	3	3	3	4	4
1.3	Дээд сургууль, коллеж	126	119	114	108	102	88
	Төрийн өмчийн	20	18	18	18	14	6
	Төрийн бус өмчийн	101	96	91	86	84	78
	Гадаадын салбар	5	5	5	4	4	4

2010-2011 оны хичээлийн жилд нийслэлд 12 их сургууль, 88 дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулсан бөгөөд тэдгээрийн 93.2 хувь нь төрийн бус өмчийн сургуулиуд байв. Дээд боловсрол олгох үйл ажиллагаа явуулж буй нийт их сургуулийн 66.7 хувийг төрийн өмчийн сургуулиуд эзэлж байна.


Хүснэгт 65. Дээд боловсрол олгох сургуульд суралцагчид, сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр

Он	Сургуулийн өмчийн хэлбэр	Нийт			Үүнээс:					
		Сургууль	Суралцагчид	Үүнээс: эмэгтэй	Их сургууль			Дээд сургууль, коллеж		
					Сургууль	Суралцагчид	Үүнээс: ислемэ	Сургууль	Суралцагчид	Үүнээс: эмэгтэй
2005	Бүгд	137	120397	71140	11	67159	39067	126	53238	32073
	Төрийн өмчийн	28	77337	43491	8	60165	34343	20	17172	9148
	Төрийн бус өмчийн	104	42776	27489	3	6994	4724	101	35782	22765
	Гадаадын салбар	5	284	160	-	-	-	5	284	160
2006	Бүгд	132	124444	73393	13	72505	42224	119	51939	31169
	Төрийн өмчийн	28	78807	44406	10	64373	37008	18	14434	7398
	Төрийн бус өмчийн	99	45452	28879	3	8132	5216	96	37320	23663
	Гадаадын салбар	5	185	108	-	-	-	5	185	108
2007	Бүгд	127	130831	78027	13	77147	45311	114	53684	32716
	Төрийн өмчийн	28	82534	47177	10	67933	39351	18	14601	7826
	Төрийн бус өмчийн	94	48009	30673	3	9214	5960	91	38795	24713
	Гадаадын салбар	5	288	177	-	-	-	5	288	177
2008	Бүгд	121	139959	82962	13	83326	48441	108	56633	34521
	Төрийн өмчийн	28	88393	49791	10	73041	41722	18	15352	8069
	Төрийн бус өмчийн	89	51293	33002	3	10285	6719	86	41008	26283
	Гадаадын салбар	4	273	169	-	-	-	4	273	169
2009	Бүгд	115	144095	85135	13	86595	49929	102	57500	35206
	Төрийн өмчийн	23	82708	44982	9	71891	39918	14	10817	5064
	Төрийн бус өмчийн	88	61143	40020	4	14704	10011	84	46439	30009
	Гадаадын салбар	4	244	133	-	-	-	4	244	133
2010	Бүгд	110	181052	103322	12	110663	64401	88	51413	31171
	Төрийн өмчийн	15	107437	57675	8	94600	53558	6	4288	1264
	Төрийн бус өмчийн	91	73339	45493	4	16063	10843	78	46849	29753
	Гадаадын салбар	4	276	154	-	-	-	4	276	154

2010 онд дээд боловсрол олгох сургуулиудад нийтдээ 181.1 мянган оюутан суралцсан бөгөөд 57.1 хувь нь эмэгтэй оюутнууд байв. Нийт суралцагчдын 53.7 хувь буюу 107.4 мянган оюутан төрийн өмчийн 15 сургуульд суралцсанаас 53.3 хувийг их сургуульд суралцагчид эзэлжээ. Харин төрийн бус өмчийн 91 сургуульд нийтдээ 73.3 мянган оюутан суралцсаны 45.5 мянга буюу 62.0 хувь нь эмэгтэй оюутнууд байв.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй гадаадын салбар сургуулиудад 0.3 мянган оюутан суралцсан байна.

Зураг 68. Өдрийн ангид суралцагчид, мян.хүн



2010-2011оны хичээлийн жилд өмчийн бүх хэлбэрийн их дээд сургууль, коллежийн дипломын дээд болон бакалаврын өдрийн ангид нийтдээ 143.9 мянга гаруй оюутан суралцсан байна. Өдрийн ангид суралцагчдын 107.4 мянга орчим нь төрийн өмчийн, 73.4 мянга нь төрийн бус өмчийн сургуульд суралцсан байна.

Гадаадын салбар сургуульд суралцагчдын хувьд 98.9 хувь нь өдрийн ангид суралцжээ. Төрийн өмчийн сургуулийн өдрийн ангид суралцагчдын 53.7 хувь, төрийн бус өмчийн сургуульд суралцагчдын 61.8 хувийг эмэгтэй оюутнууд эзэлсэн байна.

2010-2011 оны хичээлийн жилд дээд боловсрол олгох сургуульд суралцагчдын тоог өмнөх хичээлийн жилтэй харьцуулж үзэхэд бакалаврын ангид суралцагчдын тоо 10.9 хувь, магистрантурт суралцагчид 12.8 хувиар, докторантурт суралцагчид 12.7 хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн энэ хичээлийн жилд өдрөөр суралцагчдын тоо нийт суралцагчдын 88.9 хувийг эзэлж байна.

Нийслэлийн их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа оюутан сурагчдын 44.3 хувь буюу 71.8 мянган оюутан нийслэлийн харьяалалтай, 53.0 хувь буюу 90.3 мянган оюутан хөдөө орон нутгийн харьяалалтай байна.

Хүснэгт 66. Дээд боловсрол олгох сургуульд суралцагчид

Хичээлийн жил	Нийт суралцагчид					Өдрөөр суралцагчид					Орой болон эчнээгээр суралцагчид				
	Бүгд	Дипломын дээд	Бакалаврын дээд	Магистрантур	Докторантур	Бүгд	Дипломын дээд	Бакалаврын дээд	Магистрантур	Докторантур	Бүгд	Дипломын дээд	Бакалаврын дээд	Магистрантур	Докторантур
2003-2004	93563	4488	83144	4320	1611	85465	3871	75663	4320	1611	8098	696	7402		
2004-2005	108284	3972	97573	4958	1781	98526	3254	88533	4958	1781	9758	718	9040		
2005-2006	120397	2625	110326	5475	1971	109769	2263	100060	5475	1971	10628	362	10266		
2006-2007	124444	2165	114073	6118	2088	113462	1850	103406	6118	2088	10982	315	10667		
2007-2008	130831	1341	120389	7002	2099	119743	1211	109431	7002	2099	11088	130	10958		
2008-2009	139959	1683	126796	9288	2192	126235	1450	115005	7848	1932	13716	233	11783	1440	260
2009-2010	144095	1817	129772	10376	2130	127562	1389	116871	7733	1569	16533	428	12901	2643	561
2010-2011	162076	4045	143926	11704	2401	144135	4045	129597	8697	1796	17941	-	14329	3007	605

Амралт, чөлөөт цагийг өнгөрүүлэх болон соёлын үйлчилгээ


Нийслэл хотод байршиж, идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг сонины нэр төрөл, борлуулалтын хувь хэмжээ 2006 оноос эхлэн жил бүр буурч, 2009 он хүртэл нийтдээ 33 хувиар багассан байна¹.

2010 онд нийслэл хотод 101 төрлийн сонин 19.1 сая ширхэгээр борлуулагдсан байна. Сонины нэр төрөл 2009 оныхоос 5.2 хувиар, жилийн нийт борлуулалт 2.2 хувиар нэмэгджээ.

Зураг 69. Сонины тоо, борлуулалт



Зураг 70. Сонины тоо, гаралтын давтамж



Сонины зах зээлийн ихэнх буюу 73 хувийг өдөр тутмын сонин эзэлж байна. 2010 онд нийслэлд өдөр тутмын 15 сонин тогтмол гарч орон даяар түгээгдсэн бөгөөд энэ тоо сүүлийн 3 жилийн турш өөрчлөгдөөгүй байна. Гаралтын давтамжийн хувьд нийт сонины 32.7 хувь нь 10-14 хоног тутмын, 21.8 хувь нь сар тутмын, 18.8 хувь нь 7 хоног тутмын, 4.0 хувийг 3-4 хоног тутмын сонин эзэлж байгаа юм.

Сэтгүүлийн зах зээл 2000 оноос хойш өргөжиж, нэр төрөл, борлуулалтын тоо хэмжээ нь өсч 2000 онд 37 сэтгүүл жилдээ 210.0 гаруй мянган хувиар борлогдож байсан бол 2010 онд 100 гаруй нэр төрлийн сэтгүүл нийслэлд үйл ажиллагаа явуулж, борлуулалт нь 3.7 сая гаруй хувьд хүрсэн байна. Ялангуяа сүүлийн хоёр жилд сэтгүүлийн борлуулалт эрс нэмэгдсэн бөгөөд энэ нь телевизийн хөтөлбөр бүхий долоо хоног тутмын сэтгүүл олон хувиар худалдаалагдах болсонтой холбоотой.

¹ Хэвлэлийн Хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” судалгааны тайлан, 2011 он


Зураг 71. Сэтгүүлийн тоо, борлуулалтын хэмжээ



Сэтгүүлийн хэрэглээ ийнхүү огцом нэмэгдэж, нийслэлчүүдийн 38 хувь нь долоо хоног бүр аль нэг сэтгүүлийг худалдан авч байна.

2002-2006 оныг хүртэл 5 жилийн турш өдөр тутамд гарч ирсэн “Төрийн мэдээлэл” сэтгүүл 2007 оноос эхлэн долоо хоног тутмын ангилалд эргэн шилжсэнээр өдөр тутамд гардаг сэтгүүлийн тоо сүүлийн жилүүдэд байхгүй байна.

Зураг 72. Сэтгүүлийн тоо, гаралтын давтамжаар



Гаралтын давтамжийн хувьд 2010 онд долоо хоног тутам болон 10-14 хоног тутамд гардаг сэтгүүл 2 дахин нэмэгдсэн хэдий ч улирал тутмын давтамжтай сэтгүүлийн тоо давамгайлж 44.6 хувийг эзлэх болсон байна.

Нийслэл хотод 3.2 сая ширхэг номын фондтой, нийт 1672 суудал бүхий уншлагын танхимтай 28 нийтийн номын сан ажиллаж байна. 2010 онд нийтдээ 427.8 мянга гаруй хүнд 954.6 мянган ширхэг ном олгож үйлчилжээ.

Номын сангуудаас үйлчилсэн нийт номын 91.0 хувийг нь уншлагын танхимд, 7.2 хувийг гэрээр, 1.8 хувийг зөөврөөр олгожээ. Номын сангийн байнгын уншигчдын тоо 2010 онд 81.1 мянга орчимд хүрсэн байна. 2010 онд нийслэлийн номын сангууд шинээр 45.6 мянган ном авч фондын баяжилт хийсэн бол 80.7 мянган ном фондоос хасагдсан байна.


Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 14 музейд дэлгэн тавьсан нийт үзмэрийн тоо 135.7 мянгад хүрч, 209.6 мянган үзэгчдийн хүртээл болсон байна. Энд нийслэлийн Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 210 үзмэртэй орон нутаг судлах танхим багтаж байгаа бөгөөд 1.9 мянган үзэгчдэд үйлчилсэн байна. Үзмэрийн тоогоор Монголын Үндэсний музей тэргүүлсэн хэвээр байна. 2010 онд тус музейд шинээр 998 үзмэр нэмэгдэж 50.4 мянган үзмэртэй болжээ. Нийслэлд байрлалтай музейн үзмэрүүдийн үнэ цэнийг мөнгөн дүнгээр илэрхийлбэл 7.2 тэрбум төгрөгөөр үнэлэгддэг бөгөөд үүний 63.6 хувь нь Дүрслэх урлагын музей, Богд хааны ордон музей болон Чойжин ламын сүм музейд харъяалагддаг ажээ. Музейн үзэгчдийн 74.6 хувь нь Байгалийн түүхийн болон Үндэсний түүхийн, мөн Богд хааны ордон музей, Дүрслэх урлагын музейг үзэж сонирхсоны 40.3 хувийг Байгалийн түүхийн музейд зочилсон үзэгчид эзэлж байгаа юм.

Хүснэгт 67. Музейн үзмэр, үзэгчдийн тоо

Музейн нэр	Үзмэрийн тоо				Үзэгч, мянган хүн			
	2007 он	2008 он	2009 он	2010 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Байгалийн түүхийн	14120	14569	13880	14311	73.6	83.7	60.7	63.0
Монголын үндэсний музей	49357	49397	49444	50442	60.8	42.4	30.6	47.2
Дүрслэх урлаг	12812	17800	17804	17422	21.3	17.4	18.4	21.0
Богд хааны ордон музей	8131	8726	8734	8742	30.6	29.0	19.3	25.1
Чойжин ламын сүм музей	6095	6122	6191	6208	10.0	5.8	6.3	13.8
Монголын Театрын музей	9669	10282	7722	9338	4.8	3.3	3.5	2.0
Уран зургийн галерей	3066	3055	3368	3700	12.0	2.6	2.3	4.5
УБ хотын Түүх шинэчлэн байгуулалтын музей	4062	3398	3289	3339	5.1	7.1	5.7	6.7
Оюун ухааны олон улсын	8761	8938	4137	9228	8.4	12.1	11.9	11.7
Монгол төрийн түүхийн музей	-	-	-	692	-	-	-	-
Монгол цэргийн музей	4800	8593	8646	8642	11.2	6.4	5.5	10.0
Улсын хилийн музей	-	3455	3455	3455	-	2.6	2.6	2.6
Дүн	120873	134335	126870	135729	237.8	212.4	168.8	209.6

Музейн үзэгчдийн 57.1 мянга нь хүүхдүүд байгаагаас 49.1 хувь нь буюу 28.0 мянга гаруй хүүхэд Байгалийн болон Үндэсний түүхийн музейг үзсэн байна. Мөн 2010 онд манай оронд зочилсон гадаадын 75.1 мянган жуулчид дээрх музейнүүдийг үзэж сонирхсон нь нийт үзэгчдийн 35.9 хувийг эзэлж, өмнөх оныхоос музей үзсэн гадаад зочдын тоо 20.5 мянгаар нэмэгджээ.

Зураг 73. Кино театр, үзэгчдийн тоо



Нийслэл хотод 2010 онд 2284 суудал бүхий 3 кино театр үйл ажиллагаа явуулж, нийт 12515 удаагийн кино гаргалтаар 984.6 мянган үзэгчдэд үйлчилж, 4.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна. Нийт орлогын 60.0 шахам хувийг үзвэрийн орлого байна.

Кино үзэгчдийн 75.9 хувь нь Тэнгис кино театраар үйлчлүүлжээ.

2010 онд 18.2 мянган суудал бүхий 14 соёлын төв нийслэлийн иргэд, оршин суугчдад жилийн турш үйлчилж, тэдгээрт 2305 арга хэмжээ зохион байгуулагдсан байна.

Мэргэжлийн урлагын 12 байгууллагаас нийт 2026 удаагийн тоглолт хийж, 915.0 мянган үзэгчдэд хүргэжээ. Мэргэжлийн урлагын байгууллагуудын нийт тоглолтын 12.6 хувийг хүүхдэд зориулсан тоглолт эзэлж, 93.4 мянган хүүхэд багачуудад үйлчилжээ. Хүүхдэд зориулсан нийт тоглолтын 56.9 хувийг Улсын Хүүхэлдэйн Театр зохион байгуулсан байхад 17.4 мянган хүүхэд Үндэсний Дуу Бүжгийн Эрдмийн Театрт зочилж тоглолт үзсэн байна.

Хүснэгт 68. Мэргэжлийн урлагын байгууллагын суудал, тоглолтын тоо, үзэгчид


Мэргэжлийн урлагийн байгууллагын нэр	Суудлын тоо	Тоглолтын тоо				Үзэгчид, мянган хүн			
		2007 он	2008 он	2009 он	2010 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Улсын дуурь бүжгийн эрдмийн театр	500	94	122	86	85	32.0	33.3	40.0	16.0
Улсын драмын эрдмийн театр	668	140	133	125	214	36.5	39.7	31.6	58.1
Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга	599	189	173	200	201	47.5	46.2	41.1	45.3
Улсын филормони	260	134	64	152	138	35.1	21.6	35.0	56.9
Улсын хүүхэлдэйн театр	167	90	25	37	145	12.5	2.5	3.0	9.8
Монголын үндэсний цирк	2268	4	84	358	42	5.0	130.2	720.0	36.0
Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга	350	277	203	199	300	145.0	116.6	78.4	96.3
Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулга	350	-	166	54	227	-	53.6	28.6	19.0
“Түмэн-Эх” чуулга	200	240	260	260	280	115.4	12.0	12.0	13.9
УБТЗ-ын Дуу бүжгийн чуулга	400	75	51	63	108	103.4	3.6	11.4	15.8
“Сарны чулуу” чуулга	130	69	101	103	40	134.3	7.1	7.0	2.8
“Улаанбаатар” чуулга	620	19	62	62	246	98.7	700.5	909.0	545.1
Дүн	6512	1331	1444	1699	2026	765.4	1166.9	1917.1	915.0

ШАШИН ШҮТЛЭГ

2010 онд нийслэлд буддын шашны 52 хийд, христийн 72 сүм, исламын шашны 1, бусад шашны 4 сүм үйл ажиллагаа явуулжээ. Эдгээр сүм хийд нийтдээ 2069 ажиллагсадтай байгаагийн 77.8 хувь нь буддын, 21.9 хувь христын сүмүүдэд ажиллаж байна.

Нийт ажиллагсдын 65.6 хувийг хурлын лам болон христын номлогч нар эзэлж байгаа бөгөөд эдгээрийн 92.3 хувь нь буддын дацан хийдэд, 7.5 хувь нь христын сүмүүдэд харъяалагдаж байна.

Зураг 74. Сүм хийдийн тоо



Шашны сургууль, дацанд 832 хүүхэд, залуус шавилан суралцсаны сацуу шашны ном сургаалийг 3716 хүүхэд гэрээр заалгаж судалсан байна.

2010 онд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулсан албан ёсны зөвшөөрөл бүхий нийт сүм хийдийн 55.1 хувь, үүний дотор буддын дацан хийдийн 40.9 хувь, христийн сүмийн 75.0 хувь, исламын болон бусад шашны 45.5 хувь нь нийслэл хотод төвлөрсөн байв.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөл, бүртгэлтэй дээрх шашны байгууллагуудын 55.8 хувийг христийн сүмүүд эзэлж байна.

Эдгээр сүмийн 46.3 хувь нь протестант, 28.4 хувь нь эвангел урсгалыг, үлдэх хэсэг нь методист, пентикост, баптист, адвентист, католик, үнэн алдартан, морман гэх мэт христийн бусад урсгал чиглэлүүдийг төлөөлдөг ажээ.

Хүснэгт 69. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй албан ёсны зөвшөөрөлтэй сүм хийд

	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Сүм хийдийн тоо	76	92	98	113	120	129
Будда	27	29	32	35	31	52
Христ	43	60	64	70	84	72
Ислам	1			1	1	1
Бусад (Бахай, Мүүн, Бөө г.м)	5	3	2	7	4	4
Шашны сургуульд суралцагчдын тоо	4673	5161	966	951	759	832
Будда	859	836	858	878	728	795
Христ	1835	2985	108	73	29	37
Ислам	2					
Бусад (Бахай, Мүүн, Бөө г.м)	1977	1340			2	
Гэрээр ном заалгадаг хүүхэд	2055	1915	4799	4506	3780	3716
Будда	761	771	797	69	36	19
Христ	54	590	418	543	3744	3697
Ислам						
Бусад (Бахай, Мүүн, Бөө г.м)	1240	554	3584	3894	-	

Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг Монгол Улс Үндсэн хуулиараа баталгаажуулсан байдаг. Аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна² гэдгийг хуульчлан зааж өгсөн. “Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого”-ын дүнгээр арван тав, түүнээс дээш насны хүний тоо нийслэлд 871.8 мянгад хүрсэн бөгөөд эдгээр хүн амын 61.4 хувь буюу 535.4 мянган хүн шашин шүтдэг байна.

Шашинтангуудын тоог шүтдэг шашных нь төрлөөр авч үзэхэд 93.3 хувь нь монголын уламжлалт бурханы шашны болон бөө мөргөлийг шүтдэг байна. Тухайлбал, арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 53.1 хувь, шашин шүтдэг хүн амын дийлэнх буюу 86.5 хувь нь буддын шашинтан байна.

Бөөгийн шашинтай хүн амын тоо 36.4 мянгад хүрсэн нь шашин шүтдэг хүн амын 6.8 хувийг эзлэх болжээ.

Хүснэгт 70. Нийслэлийн хүн амын шашин шүтлэгийн байдал, шашны төрөл, насны бүлгээр

	15, түүнээс дээш насны	Шашин шүтдэг хүн ам	Үүнээс: Шашны төрлөөр					Шашин шүтдэг хүн амын эзлэх хувь	Шашин шүтдэг гүй	
			Будда	Христ	Ислам	Бөө	Бусад			
15, түүнээс дээш насны хүн ам - Бүгд	871860	535397	463009	26535	5901	36436	3516	61.4	336463	
Насны бүлэг	15-19	121019	63756	52315	4447	1256	5347	391	52.7	57263
	20-24	159643	92023	76242	5408	1819	7879	675	57.6	67620
	25-29	116322	70245	59886	3391	662	5775	531	60.4	46077
	30-34	97609	60100	52641	2383	512	4161	403	61.6	37509
	35-39	86563	54611	47913	2491	398	3473	336	63.1	31952
	40-44	74127	47258	41318	2199	330	3089	322	63.8	26869
	45-49	67613	43770	38277	2149	302	2765	277	64.7	23843
	50-54	52379	35102	31198	1604	218	1865	217	67.0	17277
	55-59	31323	21402	19274	952	120	926	130	68.3	9921
	60-64	22676	16127	14868	592	89	490	88	71.1	6549
	65-69	16605	11876	11035	408	78	302	53	71.5	4729
70+	25981	19127	18042	511	117	364	93	73.6	6854	


² Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт
~ 75 ~

Хүснэгт 71. Хүн амын шашин шүтлэгийн байдал, шашны төрөл, хүйс, хувиар, 2010 он

Шашны төрөл	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0
Шүтдэггүй	38.6	43.1	34.5
Шүтдэг	61.4	56.9	65.5
Будда	53.1	49.5	56.4
Ислам	0.7	0.7	0.6
Бөө	4.2	3.9	4.4
Христ	3.0	2.4	3.7
Бусад	0.4	0.4	0.4

Христийн болон уламжлалт бус бусад шашныг шүтэх явдал 1990-ээд оноос өмнө үндсэндээ байгаагүй бол өнөөгийн Монголчуудын оюун санааны амьдралд гадны шашны урсгал чиглэл нэвтрэх болсон. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор нийслэлийн 26.5 мянган иргэн христын шашинтан байгаа нь 15, түүнээс дээш насны нийт хүн амын 3.0 хувь, шашин шүтлэгтэй хүн амын 5.0 хувийг эзэлж байна. Түүнчлэн 3.5 мянган хүн бахай шүтлэг, мүүний гэх мэт бусад шашин шүтдэг ажээ.

Зураг 75. Арван тав, түүнээс дээш насны хүн амын шашин шүтлэг, насны бүлэг, хүйсээр



Шашинтангуудын дотор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү олон байна.

Арван тав, түүнээс дээш насны эрэгтэй хүн амын 56.9 хувь, эмэгтэйчүүдийн 65.5 хувь нь шашин шүтдэг байна. Шашинтангуудын 42.2 хувийг 15-30 хүртэлх насны залуучууд эзэлж байгаа юм.

Нийслэлийн суурин хүн амын зонхилох хувийг (18.3%) эзэлж буй 20-24 насны залуучуудын 57.6 хувь, түүний дотор 20-24 насны эрэгтэйчүүдийн 54.5 хувь, эмэгтэйчүүдийн 60.6 хувь нь шашинтан байна.

Хүн амын нас ахих тусам тухайн насны нийт хүн амд эзлэх шашин шүтдэг иргэдийн хувийн жин тогтмол өсөн нэмэгдсэн байна. Тухайлбал, 15-19 насны хүүхэд залуучуудын талаас илүү буюу 52.7 хувь нь шашин шүтдэг байхад 35-39 насныхны 63.1 хувь, 45-49 насны хүн амын 64.7 хувь, 55-59 насныхны 68.3 хувь, 60-аас дээш насны хүн амын 71.1-90.6 хувь нь шашин шүтдэг байна.

Шашинтангууд нас ахих тусам уламжлалт бурханы шашин илүү шүтдэг байхад христийн шашинтны эзлэх хувь нас ахих тутам буурч байна. Тухайлбал, шашин шүтдэг 15-19 насныхны 7.0 хувь, 20-29 насны залуучуудын 5.4 хувь нь христийн шашинтан байхад 60-69 насанд 3.6 хувь, 70 ба түүнээс дээш насанд 2.7 хувь болж буурч байна. Хэдийгээр буддын шашинтан нийслэлийн нийт хүн амын дунд түгээмэл байгаа боловч насны бүлгээр авч үзэхэд 15-19 насны өсвөр үеийнхний дунд христийн шашинтан илүү их байдаг байна.

Нийслэл хотод жилийн турш 308 спортын заал, танхим ажилласан байна. 2010 онд бүх нийтийг хамарсан аялал, өдөрлөг, чийрэгжилтийн арга хэмжээг 50 удаа зохион байгуулж, түүнд 278.1 мянган хүн оролцжээ. Мөн 42.0 мянган тамирчдыг хамруулсан нийслэл хотын аварга шалгаруулах 72 тэмцээн, баяр ёслол, тэмдэглэлт ойн болон нэрэмжит 112 тэмцээн зохион байгуулагдсан байна.

Хүснэгт 72. Биеийн тамир, спортын зарим үзүүлэлтүүд

	2003 он	2004 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Спортын заал, танхим, бүгд	157	160	169	172	180	210	216	308
Нийслэл хотын аварга шалгаруулах тэмцээн	28	38	28	13	16	187	164	72
Тэмцээнд оролцсон тамирчид, мянга	7.0	14.2	18.6	2.2	6.8	35.7	61.0	42.0
Бүх нийтийг хамарсан өдөрлөг, аялал чийрэгжилтийн арга хэмжээ	30	18	16	17	15	185	167	50
Үүнд хамрагдсан хүн, мянга	260.0	238.1	128.1	203.8	113.7	123.5	136.5	278.1
Баяр ёслол, тэмдэглэлт ой, нэрэмжит тэмцээн	10	18	10	10	11	165	160	112